



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ



The Asia Foundation

АЗИЙН САН



**ШҮҮГЧИЙН НӨЛӨӨЛЛИЙН МЭДҮҮЛЭГТ ДҮН
ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

2019 он
Улаанбаатар хот

Захиалагч: Шүүхийн ерөнхий зөвлөл, Азийн сан

Гүйцэтгэгч: Шүүхийн хүний нөөцийн удирдлага, бодлого зохицуулалтын газар

Судалгааны зөвлөх: Ш.Отгонцэцэг /Шүүхийн хүний нөөцийн удирдлага, бодлого зохицуулалтын газрын дарга/

Судлаач: Ж.Өнөрбаяр /Шүүгчийн хүний нөөц хариуцсан референт/



ГАРЧИГ

Товчилсон үгийн жагсаалт.....	3
Хүснэгт, зургийн товъёг	4
УДИРТГАЛ	5
НЭГ. НӨЛӨӨЛЛИЙН МЭДҮҮЛГИЙН ХӨТЛӨГДСӨН БАЙДАЛ.....	8
1.1. Нөлөөллийн мэдүүлгийн статистик тоон мэдээлэл.....	8
1.2. Нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт.....	9
1.3. Нөлөөллийн арга хэлбэр.....	10
1.4. Нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт, хууль зүйн үндэслэл /он тус бүрээр/...	12
ХОЁР.ШҮҮГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....	26
2.1. Судалгаанд хамрагдсан шүүгчдийн хүн ам зүйн байдал.....	26
2.2. Судалгааны асуулгад хариулсан байдал.....	27
ГУРАВ.ШҮҮГЧ ХАРААТ БУС, НӨЛӨӨЛЛӨӨС АНГИД БАЙХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН СУУРЬ ЗАРЧИМ, ГАДААД УЛСЫН ТУРШЛАГА.....	33
3.1. Шүүгчийн хараат бус байдлын зарчим, ангилал, баталгаа.....	33
3.2. Шүүгчийн хараат бус байдлыг хангаж хамгаалсан тухай Тайваны туршлага.....	36
ДҮГНЭЛТ, САНАЛ.....	42
Нэг. Нөлөөллийн мэдүүлгийн хөтлөгдсөн байдал.....	42
Хоёр. Шүүгчдээс авсан судалгааны үр дүн.....	43
Гурав. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал.....	47
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ.....	48
ХАВСРАЛТ	
Судалгааны асуулга.....	49

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
АТГ	Авлигатай тэмцэх газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ШТХ	Шүүхийн тухай хууль
ШЭЗБТХ	Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль
ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль
ХИТ	Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч
НИТ	Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч



Хүснэгт, зургийн товъёг

Нэг. Хүснэгт

Хүснэгт №1 Нөлөөллийн мэдүүлэг хөтлөгдсөн байдал 2013-2019 он.....	8
Хүснэгт №2 Нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн шүүгчдийн мэдээлэл.....	8
Хүснэгт №3 2013 онд хөтлөгдсөн нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт.....	12
Хүснэгт №4 2014 онд хөтлөгдсөн нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт.....	12
Хүснэгт №5 2015 онд хөтлөгдсөн нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт.....	16
Хүснэгт №6 2016 онд хөтлөгдсөн нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт.....	19
Хүснэгт №7 2017 онд хөтлөгдсөн нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт.....	21
Хүснэгт №8 2018 онд хөтлөгдсөн нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт.....	23
Хүснэгт №9 2019 онд хөтлөгдсөн нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт.....	25
Хүснэгт №10 Нийт нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт /байгууллагаар/.....	25
Хүснэгт №11 Нөлөөлөх оролдлого үзүүлсэн хэлбэр /тоо, хэмжээ/.....	27
Хүснэгт №12 Нөлөөлөх оролдлого үзүүлсэн тохиолдол /харьцуулалт/.....	28
Хүснэгт №13 Шүүгчийн хараат бус байдлыг хангахад нөлөөлөх хүчин зүйл.....	31
Хүснэгт №14 Шүүгчийн хараат бус байдлыг хангахад цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ.....	32

Хоёр. Зураг

Зураг №1 Нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт.....	9
Зураг №2 Нөлөөллийн үйлдэл, хэлбэр.....	10
Зураг №3 Шүүгчид нөлөөлөхийг оролдсон этгээд.....	11
Зураг №4 Судалгаанд хамрагдсан шүүгчдийн хүн ам зүйн байдал.....	26

Зураг №5 Судалгаанд хамрагдсан шүүгчдийн нөлөөллийн мэдүүлгийн талаарх ойлголт, хөтөлсөн байдал..... 27

Зураг №6 Судалгаанд хамрагдсан шүүгчдийн нөлөөллийн мэдүүлгийн талаарх ойлголт, хөтөлсөн байдал /харьцуулалт/.....29

Зураг №7 Нөлөөлөх оролдлого үзүүлсэн этгээд.....29

Зураг №8 Нөлөөлөх оролдлогод мэдүүлэг хөтлөөгүй шалтгаан.....30

Зураг №9 Шүүгчийн хараат бус байдлын талаарх шүүгчдийн үнэлгээ.....30

Зураг №10 Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх үр нөлөө.....31

Зураг №11 Шүүгчийн хараат бус байдлыг хангахад шүүгчийн оролцоо.....31



УДИРТГАЛ

“Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг шүүх, шүүгчийн Үндсэн хуулийн статусыг хангах явдал мөн”¹ Г.Совд

Энэхүү судалгаа нь 3 хэсэгтэй бөгөөд нэгдүгээрт Нөлөөллийн мэдүүлэг хөтлөгдсөн байдал, хоёрдугаарт Нөлөөллийн мэдүүлгийн талаар шүүгчдээс авсан судалгааны үр дүн, гуравдугаарт Шүүгч хараат бус, нөлөөллөөс ангид байх тухай олон улсын суурь зарчим, шүүгчийн хараат бус байдлыг хангаж хамгаалсан тухай гаднын улсын туршлагын талаар авч үзсэн.

Монгол Улс “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана (49.1) гэсэн Үндсэн хуулийн хэм хэмжээгээр олон улсын нийтлэг жишгийн түвшинд шүүгчийн хараат бус байдлыг хамгаалсан”² байна.

Монгол Улсад Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль 2012 оны 03 дугаар сарын 07-ны өдөр батлагдсанаар шүүгчийн хараат бус байдлыг хангаж хамгаалах эрх зүйн шинэ зохицуулалт, баталгаа бий болсон юм. Уг хуулийн 22 дугаар зүйлд шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөх зохицуулалт тусгагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн дөчин ес дүгээр зүйлийн 2-т “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй”, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан, улс төрийн нам, хуулийн этгээд, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах ажиллагааны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, шууд болон шууд бусаар нөлөөлөхийг хориглоно” гэсэн шүүгчийн хараат бус байдлын суурь зарчим бодитой хэрэгжих эрх зүйн үндэс бүрдсэн.

Ийнхүү шүүгчийн хараат бус байдлын эрх зүйн шинэ баталгаа бүрдсэн ба Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн болон Засгийн газрын гишүүн, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус, бусад аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно”, нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх тухай асуудлыг Эрүүгийн хуульд³ 1.Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчийг хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулахтай холбогдуулан өөрт нь, ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн, эсхүл ятгасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Энэ гэмт хэргийг дээд шатны албан тушаалтан, улс төрд нөлөө бүхий этгээд⁴ дарамт шахалт үзүүлж, давуу байдал бий

¹ “Монголын төр эрх зүй” сэтгүүл, УБ.,1997, №2, “Шүүх, шүүгчдийн хараат бус байдлыг хангах асуудалд” өгүүлэл, 1 дэх тал.

² Н.Лүндэндорж, Шүүх эрх мэдэл, УБ.,2017, 86 дахь тал.

³ Эрүүгийн хуулийн 21.6 дугаар зүйл. /Энэхүү зохицуулалт 2017.07.01-ээс хэрэгжиж эхэлсэн/

⁴ “Улс төрд нөлөө бүхий этгээд” гэж Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, дэд сайд, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг

болгож, бий болгохоор амлаж, ятгаж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” Зөрчлийн тухай хуульд⁵ “Шүүгчийн хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад аливаа хэлбэрээр нөлөөлөх, доромжлох, халдах, эсэргүүцэхийг оролдсон, эсхүл шүүх, шүүгчийн аюулгүй байдлын журам зөрчсөн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж хуульчилсан.

Улмаар Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхээр хүлээн авсан шүүгч, шүүх бүрэлдэхүүн нөлөөллийн мэдүүлгийг хөтөлнө.”, 22.2-т “Энэ хуулийн 22.1-д заасан нөлөөллийн мэдүүлгийн загварыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.” гэж заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл 2013 оны 06 дугаар тогтоолоор “Нөлөөллийн мэдүүлгийн загвар”-ыг баталсан.

Мөн Шүүхийн ерөнхий зөвлөл 2015 оны 23 дугаар тогтоолоор “Нөлөөллийн мэдүүлгийг шийдвэрлэх журам”-ыг баталсан бөгөөд уг журмаар Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, шийдвэрлэх ажиллагааг нарийвчлан зааж өгсөн юм.

Гэвч 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээр тус хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 60.1.1, 60.1.8, 69.1, 64.4 дэх хэсэгт заасантай “Нөлөөллийн мэдүүлгийг шийдвэрлэх журам”-ын холбогдох заалтууд нийцэхгүй нөхцөл байдал үүссэн.

Тус журмын 2.2 дахь заалтыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох, мөн 3.2, 3.6, 3.7 дахь заалтыг хэрэгсэхгүй болгохоор гаргасан иргэдийн хүсэлт, нэхэмжлэлийг шүүх хүлээн авч, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс журмын 2.2 дахь заалтыг шинэ акт гарах хугацаанд түдгэлзүүлж, 3.7 дахь заалтыг Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 60 дугаар зүйлийн 60.1.1-т заасныг үндэслэн хэрэгсэхгүй болгож тус тус шийдвэрлэсэн ба энэ нь Шүүхийн ерөнхий зөвлөл нөлөөллийн мэдүүлэгт холбогдох ажиллагааг хийж, эрх бүхий байгууллагад шилжүүлэх ажиллагаанд томоохон сорилт болсон юм.

2013-2019 онд⁶ шүүгч, шүүх бүрэлдэхүүн тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхтэй холбогдуулан 41 удаагийн нөлөөллийн мэдүүлэг хөтөлж Шүүхийн ерөнхий зөвлөлд ирүүлсний 46 хувийг холбогдох байгууллагад шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн, 41 хувийг нь шүүгчид хариу хүргүүлж шийдвэрлэсэн, 13 хувь нь ажиллагаанд байна.

Судалгааны зорилго

Судалгааг 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөл, Азийн сан хооронд байгуулсан “Санамж бичиг”-ийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.2-т “1. 2013 оноос хойш шүүгч нөлөөллийн мэдүүлэг гаргаж буй байдалд хэрэгжилт, үр дүнгийн судалгаа хийх, холбогдох статистик тоон мэдээллийг гаргах. 2.

байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргыг ойлгоно... гэж Эрүүгийн хуульд тайлбарлажээ.

⁵ Зөрчлийн тухай хуулийн 15.4 дүгээр зүйл. /Энэхүү зохицуулалт 2017.07.01-ээс хэрэгжиж эхэлсэн/

⁶ 2019 оны 10 дугаар сарын байдлаар.

...шүүгчдээс чанарын судалгааг ярилцлага хэлбэрээр авах. 3.Судалгааны үр дүнд тулгуурлан шүүгчийг нөлөөллөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх дүрэм журам, зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах, хэлэлцүүлэх ” гэж заасны дагуу 2013-2019 онд Шүүхийн ерөнхий зөвлөлд шүүгчдээс хөтлөн ирүүлсэн нөлөөллийн мэдүүлгийг шийдвэрлэсэн байдлыг судлах, шүүгчдийн нөлөөллийн мэдүүлгийн талаарх ойлголт, нөлөөлөх оролдлого бүрд нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн эсэх, хөтлөөгүй тохиолдлын шалтгаан нөхцөлийг тогтоох, “Нөлөөллийн мэдүүлэг шийдвэрлэх журам”-ын үр нөлөөг сайжруулахад цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг тодорхойлох зорилгоор анхан болон давж заалдах шатны 27 шүүхийн 132 шүүгчээс санал асуулга авч гүйцэтгэсэн.

Судалгааны зорилт

Нэг. Судалгааг гүйцэтгэх ажлын даалгавар, төлөвлөгөөг гаргах, судалгааны арга зүйг тодорхойлох;

Хоёр. 2013-2019 онд хөтөлсөн нөлөөллийн мэдүүлгийг судалж, статистик тоон мэдээллийг гаргах, дүн шинжилгээ хийх;

Гурав. Шүүгчдээс нөлөөллийн мэдүүлэгт холбогдох судалгааг авч, үр дүнг нэгтгэх;

Дөрөв. Судалгаанд үндэслэн “Нөлөөллийн мэдүүлгийг шийдвэрлэх журам”-ыг боловсронгуй болгох, нөлөөллийн мэдүүлэг хөтлөлт, шийдвэрлэлтийн үр нөлөөг сайжруулах чиглэлээр санал боловсруулах.

Судалгааны эх сурвалж

Монгол Улсын хууль тогтоомж, 2013-2019 онд хөтлөгдсөн 41 нөлөөллийн мэдүүлэг, холбогдох баримт бичиг, 132 шүүгчээс авсан санал асуулга, шүүгчийн хараат бус байдлын талаарх олон улсын суурь зарчим, зөвлөмжийн талаарх ном товхимол, Нээлттэй нийгэм форум ТББ-аас 2015 онд эмхэтгэн гаргасан “Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь” сэдэвт хэлэлцүүлэг, судалгаа эмхэтгэл, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс эрхлэн гаргадаг “Шүүх эрх мэдэл” сэтгүүлийн холбогдох дугаар, 2018 онд гадаад улсын шүүхэд туршлага судалсан талаарх тэмдэглэл, сургалтын материал зэргийг эх сурвалж болгосон.

Судалгааны арга зүй

Судалгааг тоон ба чанарын арга зүй болон харьцуулах, түүхчлэх, задлан шинжилгээ (анализ)-ний аргыг ашиглана.

Мэдээллийг баримт бичгийн судалгаа болон санал асуулгаар цуглуулж, тоо, хувь хэмжээ, ангилах, харьцуулах, бүлэглэх хэлбэрээр дүн шинжилгээ хийсэн.

НЭГ. НӨЛӨӨЛЛИЙН МЭДҮҮЛЭГ ХӨТЛӨГДСӨН БАЙДАЛ

1.1. Нөлөөллийн мэдүүлгийн статистик тоон мэдээлэл

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “нөлөөллийн мэдүүлэг гэж хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн хэрэг, маргааны шийдвэрлэлттэй холбогдуулан шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээдээс нөлөөлөх гэж оролдсон бүх үйлдлийг тэмдэглэн баталгаажуулсан, эрүү, иргэн, захиргааны хэргийн материалд хавсаргагдах баримт бичгийг” ойлгохоор заасан.

Нөлөөллийн мэдүүлэг /Цаашид “Мэдүүлэг” гэх/-ийн статистик мэдээллийг гаргахдаа 2013-2019 оны 10 дугаар сарын хооронд Шүүхийн ерөнхий зөвлөлд шүүгчдээс хөтлөн ирүүлсэн мэдүүлэг, бүртгэл мэдээлэлд үндэслэсэн.

Хүснэгт № 1 Нөлөөллийн мэдүүлэг хөтлөгдсөн байдал 2013-2019 он

Он	2013	2014	2015	2016	2017	2018	2019	Дундаж
Тоо	1	8	5	5	7	9	6	6

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль⁷ 2013 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөгдсөнөөс хойших хугацаанд нийт 41 мэдүүлгийг давхардсан тоогоор 51 шүүгч хөтлөн Шүүхийн ерөнхий зөвлөлд ирүүлжээ.

Хүснэгт № 2 Нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн шүүгчийн мэдээлэл

№	Байршил	Шүүх шат			Хэрэг маргааны төрөл			Хүйсийн харьцаа		Давтамж	Нийт	
		Анхан	Давж	Хяналт	Эрүү	Иргэн	Захиргаа	Эрэгтэй	Эмэгтэй			
1	Нийслэл	Орон нутаг	Анхан	Давж	Хяналт	Эрүү	Иргэн	Захиргаа	Эрэгтэй	Эмэгтэй	Давтамж	Нийт
2	24	17	35	5	1	8	22	11	15	36	1x1,2 ⁸	41

Шүүхийн ерөнхий зөвлөлд хөтөлж ирүүлсэн мэдүүлгийг шүүхийн байршил, хэрэг маргааны төрөл, шүүгчийн хүйсийн байдлаар ангилахад нийт мэдүүлгийн 59 хувь нь нийслэлийн шүүхээс, мэдүүлэг гаргагчдын 71 хувь эмэгтэй шүүгчид байна. Харин шүүх шатаар нь авч үзэхэд 85 хувь нь анхан шатны шүүхээс, 12 хувь нь давж заалдах шатны шүүхээс, 1 буюу 2.4 хувь тохиолдолд хяналтын шатны шүүхийн шүүгчдээс мэдүүлэг хөтөлж ирүүлсэн бол хэрэг маргааны төрлийн хувьд 54 хувь нь иргэний, 27 хувь нь захиргаа, 19 хувь нь эрүүгийн хэргийн шүүх байна. 4 тохиолдлын 2-т анхан шатны, тус бүр 1 тохиолдолд давж заалдах шатны болон хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн нөлөөллийн мэдүүлэг хөтөлж ирүүлжээ.

⁷ Уг хуулийн 22 дугаар зүйлд шүүгч, шүүн бүрэлдэхүүн шийдвэрлэж буй хэрэг маргаатайгаа холбогдуулан нөлөөллийн мэдүүлэг хөтлөх зохицуулалт анх удаа хуульчлагдсан.

⁸ 3 шүүгч тус бүр 2, нэг шүүгч 3 удаа, анхан шатны шүүхийн шүүх бүрэлдэхүүн 3, давж заалдах шатны шүүхийн шүүх бүрэлдэхүүн 2 удаа, хяналтын шатны шүүхийн шүүх бүрэлдэхүүн 1 удаа нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн байна.

1.2. Нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт

ШЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5-д “Шүүхийн ерөнхий зөвлөл энэ хуулийн 22.3⁹-т заасан нөлөөллийн мэдүүлэгт тэмдэглэн баталгаажуулсан тухайн этгээдийн үйлдэл нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан гэж үзвэл түүнийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад хандаж, шийдвэрлүүлнэ” гэж заасан.


Шүүхийн ерөнхий зөвлөл дээрх чиг үүргийн хүрээнд хөтлөн ирүүлсэн 41 мэдүүлгийн 46 хувийг холбогдох байгууллагад хандаж, шийдвэрлүүлэхээр хүргүүлсний 9 буюу 22 хувьд нь шүүгчид нөлөөлөх гэж оролдсон нь тогтоогдсон үндэслэлээр шүүхээс хөдөлмөрийн хөлсний хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөөр торгох шийтгэл ногдуулсан, 10 буюу 24 хувийг прокурорын газраас хэрэг үүсгэхээс татгалзах, хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.

Харин 17 мэдүүлэг буюу 41 хувьд нь Шүүхийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т заасныг зөрчөөгүй, нөлөөлсөн гэж үзэх үндэслэлгүй гэдгээр Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчид хариу хүргүүлсэн байна.

Зураг № 1 Нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт



⁹ Шүүгч нөлөөллийн мэдүүлгийн зорилго, хууль зөрчсөнөөс үүсэх үр дагаврын талаар хэрэг үүсгэсэн даруйд тухайн хэргийн оролцогчид тайлбарлан, энэ тухай баримтжуулна.




1.3. Нөлөөллийн арга, хэлбэр

Шүүхийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “... хэн боловч шүүгчээс шүүн таслах ажиллагааны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, шууд болон шууд бусаар нөлөөлөхийг хориглоно” гэж заасан.

Шүүхийн ерөнхий зөвлөл ШЗЭБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.2-т “Энэ хуулийн 22.1-д заасан нөлөөллийн мэдүүлгийн загварыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална” гэж заасны дагуу 2013 оны 06 дугаар тогтоолоор “Нөлөөллийн мэдүүлэг”-ийн загварыг баталсан ба уг загварт шууд болон шууд бус арга, хэрэгслээр нөлөөлөх хэлбэрийг авлига, зөвлөгөө зааварчилгаа, бусад гэсэн 3 хэсгийн 13 үйлдлээр тодорхойлж заасныг “Нөлөөллийн мэдүүлэг шийдвэрлэх журам”-ын 2.2-т “хээл хахууль, шан харамж, бэлэг сэлт өгөхийг завдах, шүүгч болон гэр бүлийн гишүүдэд албан тушаал санал болгох, дарамт шахалт үзүүлэх, дарамтлах, заналхийлэх, доромжлох, гүтгэх, шүүгчийн бие, орон байр, унааны аюулгүй байдалд халдах, шийдвэрийг урьдчилан хэлэлцэхийг санал болгох, шийдвэрийн талаар урьдчилан зааварчилгаа өгөх, нөхцөл байдлыг тайлбарлах, бусад хэрэг, маргааны шийдвэрийг жишиг болгохыг санал болгох, бусад” гэсэн үйлдлийн хэлбэрээр нарийвчлан тогтоосон байна.

2013-2019 онуудад журамд заасан нөлөөллийн хэлбэрүүдээс хээл хахууль өгөхийг завдах, дарамтлах, заналхийлэх, гүтгэх, доромжлох, шийдвэрийг урьдчилан хэлэлцэхийг санал болгох, нөхцөл байдлыг тайлбарлах зэрэг нийт 64 үйлдэлд шүүгч, шүүх бүрэлдэхүүн нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн ба үүнээс шууд болон шууд бус байдлаар дарамтлах, заналхийлэх, гүтгэх, доромжлох хэлбэрүүд дийлэнх байна. Харин авлига, хээл хахууль санал болгох хэлбэрээр нөлөөлөх гэж оролдсон нэг тохиолдолд шүүхээс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ.

Зураг № 2 Нөлөөллийн үйлдэл, хэлбэр



Шүүхээр шийдвэрлэсэн нөлөөллийн мэдүүлэгт тусгагдсан үйлдлийн хэлбэр нь шууд болон шууд бусаар дарамтлах, заналхийлэх 5, шууд бусаар гүтгэж доромжлох 3, шууд болон шууд бусаар дарамт, шахалт үзүүлэх 1, хээл хахууль өгөхийг завдах үйлдэл 1 байна.

Харин нөлөөллийн мэдүүлэгт холбогдох хэргийг шүүх шийдвэрийн үндэслэлээ ШТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1-т “Төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан, улс төрийн нам, хуулийн этгээд, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах ажиллагааны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, шууд болон шууд бусаар нөлөөлөхийг хориглоно” гэж заасныг зөрчсөн, шүүгчид нөлөөллийг оролдсон нь тогтоогдсон гэсэн ерөнхий байдлаар тодорхойлжээ.

Дээрх хугацаанд шүүгчид нөлөөлөхийг оролдсон этгээдийг ангилан авч үзвэл, хариуцагч болон нэхэмжлэгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нар нийт нөлөөлөх оролдлогын 61 хувийг эзэлж байгаа юм.

Зураг № 3 Шүүгчид нөлөөлөхийг оролдсон этгээд



Шүүгчид нөлөөлөх оролдлого үзүүлсэн этгээдүүдийн ихэнх нь хэргийн оролцогч байна. Харин шүүгч шүүгчдээ нөлөөлөх оролдлого хийсэн талаар нэг тохиолдол ирснээс шийдвэрлэсэн тохиолдол байхгүй.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “... шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээдээс нөлөөлөх гэж оролдсон бүх үйлдлийг тэмдэглэн баталгаажуулсан, эрүү, иргэн, захиргааны хэргийн материалд хавсаргагдах баримт бичгийг” ойлгохоор заасан. Аливаа этгээд гэдгийг Улсын Дээд шүүхийн 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 1 дүгээр зөвлөмжөөр “Аливаа этгээд” гэдэгт Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд болон бусад байгууллага хамаарна” гэжээ.

2017 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах хэлтсээс анхан болон давж заалдах шатны шүүхийн 116 шүүгчдийн дунд шүүхийн хараат бус байдлын талаар санал асуулга явуулжээ. Энд “Таны шийдвэрлэхээр хүлээн авсан хэрэг маргаанд нөлөөлөхийг оролдож байсан албан тушаалтан” гэсэн асуултад 7 шүүгч дээд болон тухайн шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч гэж хариулсан байна.

Харин дээрх хугацаанд шүүгчид холбогдуулж нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн тохиолдол нэг гарсан бөгөөд 2019 онд анхан шатны шүүхийн нэг шүүгчээс Ерөнхий шүүгчдээ холбогдуулан нөлөөллийн мэдүүлэг хөтөлж ирүүлсэн. Гэвч нөлөөлөхийг оролдсон гэх үйлдэл нь 2018 оны 3 сард болсон ба Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ШЭЗБТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаад дууссан тул холбогдох ажиллагаа хийх боломжгүй гэх үндэслэлээр тухайн шүүгчид хариу өгсөн.

Мөн дээрх судалгааны танилцуулгад “шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх боломжтой этгээд” гэсэн асуултад дээд шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч 10, тухайн шатны шүүгч, Ерөнхий шүүгч 7, ШЕЗ-ийн дарга, гишүүд 2, шүүхийн тамгын газрын дарга 2, шүүхийн захиргааны ажилтан 3 гэж тус тус хариулсан нь анхаарал татаж байгаа юм.

Дээрх судалгааны үр дүнд шүүхийн дотоод хараат бус байдал хангалттай сайн биш, шүүгч нар зөвхөн хэргийн оролцогчдоос үзүүлж байгаа үйлдэлд нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг, харин шүүхийн хамаарал бүхий этгээдийн үйлдэлд нөлөөллийн мэдүүлэг хөтлөхгүй гэж дүгнэжээ.

1.4. Нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт, хууль зүйн үндэслэл /он тус бүрээр/

Хүснэгт №3 2013 онд хөтлөгдсөн нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт

№	Тоо	Нөлөөлсөн этгээд	Арга, хэлбэр	Шийдвэрлэсэн байгууллага	Шийдвэрийн нэр, үндэслэл	Авсан арга хэмжээ
1.	1	Нэхэмжлэгчийн өмгөөлөгч	Шууд /шийдвэрийг урьдчилан хэлэлцэхийг санал болгох, нөхцөл байдлыг тайлбарлах/	Дүүргийн прокурорын газар	Тогтоол, “... шүүгчид нөлөөлөхөөр завдсан байх боловч хэрэг үүсгэх хөөн хэлэлцэх хугацаа дууссан.”	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 6 сарын дараа анхны мэдүүлэг хөтөлж ирүүлсэн нь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч байсан юм. Нэхэмжлэгчийн өмгөөлөгч шүүгчид нөлөөлөх гэж оролдсон нь прокурорын байгууллагаас тогтоогдсон боловч хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэжээ.

Хүснэгт №4 2014 онд хөтлөгдсөн нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт

№	Тоо	Нөлөөлсөн этгээд	Арга, хэлбэр	Шийдвэрлэсэн байгууллага	Шийдвэрийн нэр, үндэслэл	Авсан арга хэмжээ
1.	8	Нэхэмжлэгчийн ээж	Шууд бус /шийдвэрийг урьдчилан хэлэлцэхийг санал болгох, дарамтлах, заналхийлэх/	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Шийтгэвэр, “... шүүгчид нөлөөлөхийг оролдсон болох нь нотлох баримтаар тогтоогдсон.”	Торгох шийтгэл ногдуулсан.
2.		Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	Шууд бус /гүтгэж, доромжлох, мэдээллийн хэрэгсэл ашигласан/	Дүүргийн прокурорын газар	Тогтоол, “... үндэслэлгүй тул ЭБШХ-ийн 175 дугаар зүйлийг үндэслэн”	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан.
3.		Хэргийн оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	Шууд /дарамтлах, заналхийлэх/	Сум дундын шүүхийн шийтгэвэр	Шийтгэвэр, “... шүүгчээс удаа дараа үндэслэлгүйгээр татгалзаж байсныг дарамтлах, заналхийлсэн хэлбэрээр нөлөөлсөн гэж дүгнэх үндэслэлтэй.”	Торгох шийтгэл ногдуулсан.
4.		Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	Шууд /Дарамтлах, заналхийлэх/ Шууд бус /Гүтгэх, доромжлох,	Дүүргийн прокурорын газар	Тогтоол, “... ЭБШХ-ийн 208.1.2, 209.1 дэх хэсгийг үндэслэн”	Хэргийг хэрэгсэхгүй болгосон.

			мэдээллийн хэрэгсэл ашигласан/			
5.	Захиргааны хэрэгт гуравдагч этгээдээр оролцогч	Шууд бус /Шүүгчийг “шунахайн болон хувийн сэдэлтээр илт хууль бус шийдвэр гаргах” гэмт хэргийг үйлдсэн тухай гомдол гаргасан/	Дүүргийн прокурорын газар	Тогтоол, “... гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлгүй тул ЭБШХ-ийн 175 дугаар зүйлийг үндэслэн”	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	
6.	Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	Шууд бус /дарамтлах, заналхийлэх, гүтгэх, доромжлох, шүүгчийг согтуу гэж гүтгэж, нэр төрд халдсан. Олон нийтийн сүлжээгээр тараасан./	Дүүргийн прокурорын газар	Тогтоол, “... эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлгүй тул ЭБШХ-ийн 175 дугаар зүйлийг үндэслэн”	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	
7.	Хариуцагч тал	Шууд бус / гүтгэх, доромжлох, Шүүгч нар шүүх хурал бүрд манай байгууллагын эсрэг шийдвэр гаргадаг/	Дүүргийн прокурорын газар	Тогтоол, “... гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлгүй тул ЭБШХ-ийн 175 дугаар зүйлийг үндэслэн”	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	
8.	Гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	Шууд бус /гүтгэх, доромжлох, хуурамч тогтоол гаргасан, бусад шүүгчид нөлөөлсөн/	Дүүргийн прокурорын газар	Тогтоол, “... алдар хүндийг гутаасан нь тогтоогдохгүй, эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлгүй тул ЭБШХ-ийн 175 дугаар зүйлийг үндэслэн”	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	

2014 онд 8 шүүгч мэдүүлэг хөтөлж ирүүлснийг Шүүхийн ерөнхий зөвлөл хүлээн авч, холбогдох байгууллагад хүргүүлснээс шүүгчид нөлөөлөх оролдлого хийсэн хоёр этгээдэд шүүхээс торгох шийтгэл ногдуулжээ. Харин бусад мэдүүлгийг Нийслэлийн дүүргийн прокурорын газраас нөлөөлсөн гэх үйл баримт тогтоогдохгүй гэх үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.

▪ **Шүүхээр шийдвэрлэгдсэн мэдүүлэг /Хүснэгтийн 1, 3-т заасан/**

Тохиолдол №1

Нэхэмжлэгчийн ээжид холбогдох мэдүүлгийг Шүүхийн ерөнхий зөвлөл хүлээн авч, хянаад, Гүйцэтгэх нарийн бичгийн даргын тоот албан бичгээр “... иргэн нь шүүгч хэрэг, маргааныг хараат бусаар хянан шийдвэрлэхэд хөндлөнгөөс нөлөөлөх шинжтэй, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн байж болзошгүй үйлдэл гаргасан байна” гэх үндэслэлээр ШЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэгт заасны дагуу асуудлыг шалгуулж, шийдвэрлүүлэхээр мэдүүлгийг холбогдох баримтын хамт Нийслэлийн Сүхбаатар дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтэс /цаашид Цагдаагийн хэлтэс гэх/-т шилжүүлсэн байна.

Цагдаагийн хэлтэс “иргэн 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо, Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 1-р шүүхийн шүүгчийн албан тасалгаанд шүүгчид нөлөөлөхийг оролдсон тул Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар захиргааны арга хэмжээ авч өгнө үү” гэсэн хүсэлтийг Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхэд хүргүүлжээ.

Шүүхээс “шүүгчид нөлөөлөхийг оролдсон болох нь зөрчил гаргагчийн тайлбар, мэдүүлэг, зөрчлийн тухай тэмдэглэл, ШЕЗ-ийн 2014.04.13-ны өдрийн 03/931 тоот албан бичиг, нэхэмжлэгч, нэхэмжлэгчийн ээжийн шүүгчтэй уулзсан тэмдэглэл, ШЕЗ-д гаргасан шүүгчийн тайлбар, CD зэрэг нотлох баримтуудаар тогтоогдож байх тул Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30 дугаар зүйлд зааснаар торгох шийтгэл ногдуулах нь үндэслэлтэй гэж үзэж” 15000 /арван таван мянга/ төгрөгөөр торгох шийтгэл ногдуулжээ.

Процесс зураглал №1



Тохиолдол №2

Нэхэмжлэгч болон хариуцагч нарын итгэмжлэгдсэн төлөөлөгчид холбогдох мэдүүлгийг Шүүхийн ерөнхий зөвлөл хүлээн авч, хянаад Гүйцэтгэх нарийн бичгийн даргын тоот албан бичгээр “иргэний үйлдэл нь шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх шинжтэй ба Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг зөрчсөн байж болзошгүй байна” гэх үндэслэлээр ШЭЗБТХ-ийн 38 дугаар зүйлд заасны дагуу хянан шийдвэрлүүлэхээр шүүгчийн нөлөөллийн мэдүүлгийн холбогдох баримтын хамт Сум дундын 14 дүгээр шүүхэд шилжүүлсэн байна.

Шүүхээс нотлох баримтыг хянан үзээд “шүүгчээс удаа дараа үндэслэлгүйгээр татгалзаж байсныг дарамтлах, заналхийлсэн хэлбэрээр нөлөөлсөн гэж дүгнэх үндэстэй байх тул иргэнд Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж” 25000 /хорин таван мянга/ төгрөгөөр торгох шийтгэл ногдуулжээ.

Процесс зураглал №2



- **Прокурор хэргийг хэрэгсэхгүй болгосон, хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн мэдүүлэг /хүснэгтийн 2, 4,5,6,7,8-т заасан/**

Тохиолдол №3

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нарт холбогдох мэдүүлгийг Шүүхийн ерөнхий зөвлөл хүлээн авч, хянаад, Гүйцэтгэх нарийн бичгийн даргын тоот албан бичгээр “... иргэний үйлдэл нь Эрүүгийн хуулийн 110, 111, 259 дүгээр¹⁰ зүйлүүдэд заасан гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй байна” гэх үндэслэлээр ШЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэгт заасны дагуу асуудлыг шалгуулж шийдвэрлүүлэхээр мэдүүлгийг холбогдох баримтын хамт Нийслэлийн Цагдаагийн хэлтэст шилжүүлсэн байна.

¹⁰ Хуучин эрүүгийн хуулийн 110, 111, 259 дүгээр зүйлүүдэд доромжлох, гүтгэх тохиолдолд ял шийтгэх заалт байсан.

Цагдаагийн хэлтэс “Эрүүгийн хуулийн тусгай ангийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан иргэнд холбогдох эрүүгийн 2014250003124 дугаартай хэргийг хэрэгсэхгүй болгох санал гаргаж” Дүүргийн нэгдүгээр прокурорын газар /цаашид Прокурор гэх/-т хүргүүлжээ.

Прокурор “шүүгчийг гүтгэсэн, мөн бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө доромжилсон, хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэгийг олон нийтэд тараасан гэх хэргийг шалгуулж нэмэлт номлох баримтыг цуглуулах бүхий л ажиллагааг хийсэн, эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч яллагдагчийн гэм буруутай эсэхэд эргэлзээтэй, яллагдагчид ашигтайгаар шийдвэрлэх нь үндэслэлтэй байх тул хэргийг хэрэгсэхгүй болгосугай” гэж шийдвэрлэжээ.

Процесс зураглал №3



Тохиолдол №4

Прокурорын газраас эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн бусад нөлөөллийн мэдүүлгийн тухайд, ШЕЗ-өөс нөлөөллийн мэдүүлгийг хүлээн авч, хянаад Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан, улс төрийн нам, хуулийн этгээд, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах ажиллагааны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, шууд болон шууд бусаар нөлөөлөхийг хориглоно.” гэсэн заалтыг зөрчиж, шүүгчид нөлөөлөхийг оролдсон гэж үзэхээр байна гэх үндэслэлээр ШЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5-т заасны дагуу Цагдаагийн хэлтэст шалгуулахаар шилжүүлсэн байна.

Цагдаагаас эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай санал гаргаж Прокурорын хяналтад шилжүүлснийг прокурор хянаад эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн. Харин ШЕЗ тус нөлөөлөлд холбогдох асуудлыг “тухайн нөлөөлсөн гэх үйл баримт нь эрүүгийн эрх зүйн зөрчлийн шинжийг агуулаагүй ч Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т заасныг зөрчиж, шүүгчид нөлөөлөхийг оролдсон гэж үзэхээр байгаа тул гаргасан зөрчлийг шалгаж өгөх” талаар Цагдаагийн газарт дахин хандсан байна. Гэвч цагдаагийн газраас эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай саналыг прокурорын хяналтад шилжүүлж, прокурор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэжээ. Тухайн үеийн Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан зөрчилд Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан захиргааны хариуцлага хүлээлгэх харьяалалгүй, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д зааснаар шүүгч хянан шийдвэрлэхээр байсан.

Процесс зураглал №4



Хүснэгт №5 2015 онд хөтлөгдсөн нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт

№	Тоо	Нөлөөлсөн этгээд	Арга, хэлбэр	Шийдвэрлэсэн байгууллага	Шийдвэрийн нэр, үндэслэл	Авсан арга хэмжээ
1.	5	Шүүгдэгч	Шууд /Хээл хахууль, шүүгчид 500 мянган төгрөг авахыг санал болгосон./	Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Шүүгчийн захирамж, "...ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн, шүүгчид нөлөөлөхийг оролдсон."	Торгох шийтгэл ногдуулсан.
2.		УИХ-ын гишүүн /хянан шийдвэрлэж буй хэрэг маргаан тодорхой бус/	Шууд бус /Дарамт шахалт үзүүлэх, гүтгэх, доромжлох, шүүгчийн ажиллагаанд байгаа ямар нэгэн хэргийн талаар УИХ-ын гишүүн Б үндэслэлгүй мэдээлэл тараасан/	Шүүхийн ерөнхий зөвлөл	Шүүгчийн хянан шийдвэрлэж буй ямар хэрэг маргааны талаар мэдээлэл хийсэн нь тодорхой бус тул ШЭЗБТХ-ийн 3.1.2, Нөлөөллийн мэдүүлгийн маягтын 1.3-т заасныг үндэслэн	Нөлөөлөх оролдлого хийсэн гэж үзэх үндэслэлгүй тухай шүүгчид хариу өгсөн.
3.		Шүүгдэгч	Шууд /дарамт шахалт үзүүлэх, шийдвэрийн талаар урьдчилсан зааварчилгаа өгөх, шүүгчийн бие, орон байр, унааны аюулгүй байдалд халдах/	Дүүргийн прокурорын газар	Тогтоол, "...Шүүгчид нөлөөлөх зорилгоор шүүгчийн албан өрөөний гадна зогсож, үг чагнах оролдлого гаргасан нь тогтоогдоогүй тул ЭБШХ-ийн 175 дугаар зүйлийг үндэслэн"	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан
4.		Шүүгдэгчийн өмгөөлөгч	Шууд бус / гүтгэх, доромжлох, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашигласан/	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Шүүгчийн захирамж, "...ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн, шүүгчид нөлөөлөхийг оролдсон."	Торгох шийтгэл ногдуулсан.
5.		Хариуцагч	Шууд, шууд бус /дарамт шахалт үзүүлэх, шийдвэрийн талаар урьдчилсан зааварчилгаа өгөх, телевизээр шүүгч энэ хэргийг яаж шийдэх юм бол хэрвээ эсрэг шийдвэр гарвал.../	Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Шүүгчийн захирамж, "...ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн, шүүгчид нөлөөлөхийг оролдсон."	Торгох шийтгэл ногдуулсан.

2015 онд хөтөлж ирүүлсэн 5 нөлөөллийн мэдүүлгийн 3-т "...ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн, шүүгчид нөлөөлөхийг оролдсон." гэх үндэслэлээр шүүхээс торгох шийтгэл ногдуулсан ба 1 нөлөөллийн мэдүүлэгт ШЭЗ "нөлөөлөхийг оролдсон гэх этгээд тухайн шүүгчийн хянан шийдвэрлэж буй ямар хэрэг маргааны талаар мэдээлэл хийсэн нь тодорхой бус тул ШЭЗБТХ-ийн 3.1.2, Нөлөөллийн мэдүүлгийн маягтын 1.3-т заасныг үндэслэн шүүгчид нөлөөлөх оролдлого хийсэн гэж үзэх үндэслэлгүй тухай шүүгчид хариу хүргүүлсэн. Харин нэг мэдүүлгийг нөлөөлсөн гэх үйлдэл тогтоогдохгүй гэх үндэслэлээр Прокурорын газар эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.

■ **Шүүхээр шийдвэрлэгдсэн мэдүүлэг /Хүснэгтийн 1, 4, 5-т заасан/**

Тохиолдол №1

Шүүгдэгчид холбогдох нөлөөллийн мэдүүлгийг Шүүхийн ерөнхий зөвлөл хүлээн авч, хянаад, ШЕЗ-ийн даргын тоот албан бичгээр МУ-ын Ерөнхий прокурорын орлогч прокурорт "... үүрэн холбооны оператор ХХК-аас холбогдох мэдээллийг авах зөвшөөрөл олгож өгөхийг хүсэж ШЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэгт заасны дагуу асуудлыг шалгуулж шийдвэрлүүлэхээр шүүгчийн нөлөөллийн мэдүүлгийг хүргүүлснийг Ерөнхий прокурорын газар "... бусдад хээл хахууль өгөхийг завдсан гэмт хэргийн шинжтэй асуудал"-ыг шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.

АТГ-аас "тухайн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, дугаар авахаар Нийслэлийн прокурорын газарт хүргүүлсэн боловч тус газрын хяналтын прокурор эрүүгийн хэрэг үүсгэх тогтоолыг хүчингүй болгож, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан байна. Иймд ШЭЗБТХ-ийн 38 дугаар зүйлд заасныг үндэслэн шүүгдэгчийн шүүгчтэй утсаар ярьсан асуудалд хуулийн дагуу зохих хариуцлагыг хүлээлгүүлэх асуудлыг шийдвэрлүүлэхээр хүргүүлэв" гэсэн албан тоотыг ШЕЗ-д ирүүлжээ.

ШЕЗ уг нөлөөллийн мэдүүлгийг "ШТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтыг зөрчиж, шүүгчид нөлөөлөхийг оролдсон гэж үзэхээр байна" гэсэн үндэслэлээр Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хүргүүлснийг тус шүүхээс хянаад "шүүгдэгчийн үйлдэл нь ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн, шүүгчид нөлөөлөхийг оролдсон үйлдэл мөн" гэж үзэн, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож шийдвэрлэжээ.

Процесс зураглал №5



Тохиолдол №2.

Шүүгдэгчийн өмгөөлөгчид холбогдох нөлөөллийн мэдүүлгийн ШЕЗ хүлээн авч, хянаад "ШТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтыг зөрчиж, шүүгчид нөлөөлөхийг оролдсон гэж үзэхээр байна" гэх үндэслэлээр ШЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5-д заасны дагуу Цагдаагийн хэлтэст шилжүүлсэн. Цагдаагийн хэлтсээс эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай саналаа прокурорт шилжүүлснийг прокурор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэжээ.

ШЕЗ уг нөлөөллийн мэдүүлгийн асуудлыг шүүхэд шилжүүлснийг шүүх хянаад, "өмгөөлөгчийн үйлдэл нь эрүүгийн эрх зүйн зөрчлийн шинжийг агуулаагүй боловч ШТХ-ын 27 дугаар зүйлийн 27.1-т заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна гээд ШЭЗБТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт зааснаар өмгөөлөгчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож" шийдвэрлэсэн байна.

Процесс зураглал №6



Тохиолдол №3

Захиргааны хэргийн хариуцагчид холбогдох нөлөөллийн мэдүүлгийг Шүүхийн ерөнхий зөвлөл хүлээн авч, хянаад, "...ШТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасныг зөрчсөн гэж үзэхээр байна" гэх үндэслэлээр ШЭЗБТХ-ийн 38 дугаар зүйлд зааснаар иргэнд хариуцлага хүлээлгэх эсэх асуудлыг хянан шийдвэрлүүлэхээр харьяалах шүүхэд хүргүүлснийг шүүх хянаад "шүүгчийн өрөөнд шууд орж маргаан үүсгэсэн үйлдэл нь ШТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтыг зөрчин шүүгчид шууд болон шууд бус хэлбэрээр нөлөөлөхийг оролдсон гэж үзэх үндэслэлтэй байна" гээд нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож шийдвэрлэжээ.

Процесс зураглал №7



- **ШЭЗ, Прокурор шийдвэрлэгдсэн мэдүүлэг /Хүснэгтийн 2, 3-т заасан/**

Тохиолдол №4

УИХ-ын гишүүний "шүүгчийн хянан шийдвэрлэж буй тодорхой бус хэрэг маргааны талаар" телевизээр ярьсан зүйлтэй холбогдуулж хөтөлж ирүүлсэн нөлөөллийн мэдүүлгийг ШЭЗ хүлээн авч, хянаад "шүүгчийн хянан шийдвэрлэж буй ямар хэрэг маргааны талаар мэдээлэл хийсэн нь тодорхой бус тул ШЭЗБТХ-ийн 3.1.2, Нөлөөллийн мэдүүлгийн маягтын 1.3-т заасныг үндэслэн нөлөөлөх оролдлого хийсэн гэж үзэх үндэслэлгүй тухай шүүгчид хариу өгч шийдвэрлэсэн.

Процесс зураглал №8



Тохиолдол №5

Шүүгдэгчид холбогдох нөлөөллийн мэдүүлгийг ШЭЗ хүлээн авч, хянаад тухайн этгээдийн үйлдэл нь ШТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасныг зөрчиж, шүүгчид нөлөөлөхийг оролдсон гэж үзэн, ШЭЗБТХ-ийн 38 дугаар зүйл, Нөлөөллийн мэдүүлэг шийдвэрлэх журмын 3.6-т заасныг баримтлан шийдвэрлүүлэх хүсэлтийг харьяалах шүүхэд хүргүүлснийг тухайн шүүхээс "Нөлөөллийн мэдүүлгийг шийдвэрлэх журмын 3.5-д "...Шүүгчийн хараат бус байдалд халдсан үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй гэж Ерөнхий зөвлөл үзвэл ШЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5-д заасны дагуу нөлөөллийн мэдүүлэгт тэмдэглэн баталгаажуулсан этгээдийг шалгуулахаар нөлөөллийн мэдүүлэг, түүнд холбогдох баримт бичгийг Цагдаагийн байгуулга, Авлигатай тэмцэх газарт шилжүүлнэ", 3.6-д "... Шүүгчийн хараат бус байдалд халдсан үйлдэлд ШЭЗБТХ-ийн 38 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэхээр байвал нөлөөллийн мэдүүлэг хариуцсан ажилтан Ерөнхий зөвлөлийн хүсэлт, нөлөөллийн мэдүүлэг, түүнд холбогдох баримт бичгийг харьяалах шүүхэд шилжүүлнэ" гэж тус тус заасан тул холбогдох байгууллагаар шалгаж хариуцлага тооцох үндэслэлтэй гэж үзвэл шүүх хүлээн авч холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэх үндэслэлтэй тул албан бичгийг буцаан хүргүүлж байна" гэжээ.

Иймд ШЕЗ “шүүгдэгчийн үйлдэл нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан гэж үзэж” ШЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэгт заасны дагуу Цагдаагийн хэлтэст хүргүүлснийг тус хэлтсээс хойшлуулшгүй ажиллагаа явуулж эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналаа Прокурорын газарт хүргүүлснийг Прокурор хянаад “шүүгдэгч нь шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх зорилгоор шүүгчийн албан өрөөний гадна зогсож, үг чагнах оролдлого гаргасан нь тогтоогдоогүй, мөн Эрүүгийн хуульд шүүгчийн хараат бус байдалд халдсан буюу нөлөөлөхийг завдсан үйлдэл, эс үйлдэхүйд хүлээлгэх хариуцлагыг зохицуулсан зүйл заалт байхгүй тул эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлгүй” гэж шийдвэрлэжээ.

Процесс зураглал №9



Хүснэгт №6 2016 онд хөтлөгдсөн нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт

№	Тоо	Нөлөөлсөн этгээд	Арга, хэлбэр	Шийдвэрлэсэн байгууллага	Шийдвэрийн нэр, үндэслэл	Авсан арга хэмжээ
1.	5	Хэрэг маргааны оролцогч эсэх нь тодорхойгүй	Шууд бус /дарамтлах, заналхийлэх, гүтгэх доромжлох, шүүгчийн эхнэрийн утсаар шүүгчийг ална гэж сүрдүүлсэн/	Дүүргийн прокурорын газар	Тогтоол, "...шүүгчийг тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэх явцад нөлөөлөх оролдлого хийгээгүй тул ШЭЗБТХ-ийн 3.1.2, Нөлөөллийн мэдүүлгийн маягтын 1.3-т заасныг үндэслэн"	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан
2.		Хэргийн оролцогч	Шууд бус /гүтгэх, доромжлох, шүүхийн ёс зүйн хороонд үндэслэлгүй гомдол гаргасан/	Шүүхийн ерөнхий зөвлөл	Шүүгчийг гүтгэсэн гэх үйлдэл нь мэдүүлэгт хавсаргасан болон бусад баримтаар тогтоогдохгүй, хэргийн оролцогч ёс зүйн хороонд гомдол гаргасан нь хуульд заасан эрхээ эдэлсэн.	Нөлөөлөх оролдлого хийсэн гэж үзэх үндэслэлгүй тухай шүүгчид хариу өгсөн.
3.		Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	Шууд бус /дарамтлах, заналхийлэх, гүтгэх доромжлох, нөхцөл байдлыг тайлбарлах/	Шүүхийн ерөнхий зөвлөл	Тухайн хэрэг, маргааны шийдвэрлэлттэй холбогдуулан шүүгч, шүүх бүрэлдэхүүнд нөлөөлөхийг оролдсон гэх үндэслэл байхгүй, өмгөөлөгчийн үйлдэл ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчөөгүй.	Нөлөөлөх оролдлого хийсэн гэж үзэх үндэслэлгүй тухай шүүгчид хариу өгсөн.
4.		Хариуцагчийн өмгөөлөгч	Шууд /бусад, шүүгчдийг ажлын хариуцлага алдсан, ёс зүйн алдаа гаргасан гэж ШЭЗХ-д өгч шалгуулна гэх/ Шүүх бүрэлдэхүүн гаргасан	Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Шүүгчийн захирамж, "...өмгөөлөгч нөлөөллийн мэдүүлэгтэй танилцаж, гарын үсэг зурж, баталгаажуулаагүй."	ШЕЗ-ийн хариуцлага хүлээлгэх тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

5.	Нэхэмжлэгч	Шууд бус /Дарамтлах, заналхийлэх, Шүүгч та шүүн таслах ажиллагааг үнэн зөвөөр шийдэж өгөх үү гэх хүсэлт гаргасан/	Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Шүүгчийн захирамж, "...иргэний гаргасан хүсэлт, тайлбар нь ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн."	Торгох шийтгэл ногдуулсан.
----	------------	---	---	--	----------------------------

2016 онд 5 нөлөөллийн мэдүүлэг хөтлөгдсөн ба ШЕЗ хууль тогтоомжид заасан ажиллагааг явуулж хэргийн оролцогч, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид холбогдох 2 нөлөөллийн мэдүүлэгт “шүүгчийг гүтгэсэн гэх үйлдэл нь мэдүүлэгт хавсаргасан болон бусад баримтаар тогтоогдохгүй, хэргийн оролцогч ёс зүйн хороонд гомдол гаргасан нь хуульд заасан эрхээ эдэлсэн, тухайн хэрэг, маргааны шийдвэрлэлттэй холбогдуулан шүүгч, шүүх бүрэлдэхүүнд нөлөөлөхийг оролдсон гэх үндэслэл байхгүй тул ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчөөгүй” гэх үндэслэлээр шүүгчид хариу өгчээ. Харин 2 мэдүүлгийг шүүхээр хянан шийдвэрлэсэн, 1 мэдүүлгийг прокуророос эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлгүй гэж шийдвэрлэжээ.

- **Прокурор шийдвэрлэгдсэн мэдүүлэг /Хүснэгтийн 1-т заасан/**

Тохиолдол №1

Шүүгчээс хэрэг маргааны оролцогч эсэх нь тодорхойгүй этгээдэд холбогдох нөлөөллийн мэдүүлэг ирүүлснийг ШЕЗ хүлээн авч, танилцаад иргэний утсаар заналхийлж ярьсан үйлдэлд нь “шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан гэж үзэж байгаа тул шалгаж өгнө үү” гэсэн хүсэлтийг ШЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5-д заасны дагуу Цагдаагийн хэлтэст хүргүүлснийг тус хэлтсээс харьяаллын дагуу дүүргийн прокурорын газарт шилжүүлжээ.

Прокурорын газраас “...утсаар заналхийлж ярьсан этгээд нь хувийн таарамжгүй харилцааны улмаас шүүгч болон эхнэрийн гар утас руу залгаж хэл амаар доромжилсон байх бөгөөд шүүгчийн хэрэг маргаан хянан шийдвэрлэх үйл ажиллагаа явуулахад нь нөлөөлж, хараат бус, бие даасан байдалд нь халдаагүй байх тул эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлгүй байна” гэжээ.

Процесс зураглал №10



- **Шүүхээр шийдвэрлэгдсэн мэдүүлэг /Хүснэгтийн 4, 5-т заасан/**

Тохиолдол №2

Харин шүүхээр шийдвэрлэгдсэн хариуцагчийн өмгөөлөгч, нэхэмжлэгч нарт холбогдох 2 нөлөөллийн мэдүүлгийг ШЕЗ хүлээн авч, танилцаад “холбогдох этгээдийн үйлдэл нь ШТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасныг зөрчсөн гэж үзэхээр байгаа тул ШЭЗБТХ-ийн 38 дугаар зүйлд зааснаар тухайн этгээдэд хариуцлага хүлээлгэх эсэх асуудлыг хянан, шийдвэрлэх” хүсэлтийг харьяалах шүүхэд тус тус хүргүүлсэн байна.

ШЕЗ-ийн зөвлөлийн хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн шүүгчийн захирамжид “мэдүүлэгт холбогдох этгээдийн шүүх хуралдааны явцад нөлөөлөх

оролдлогын шинжтэй зүйл ярьсан нь шүүх хуралдааны тэмдэглэл, танхимын дуу, дүрсний бичгээр тогтоогдож байгаа боловч тухайн этгээдэд /өмгөөлөгч/ нөлөөлөх оролдлого гаргасан тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэх талаар танилцуулж, гарын үсэг зуруулж, баталгаажуулаагүй байх тул өмгөөлөгчийг шүүгчийн хараат бус байдалд нөлөөлсөн гэж үзэж, хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэлгүй” гэж дүгнээд ШЕЗ-ийн дээрх үндэслэлээр гаргасан хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Харин ШЕЗ-ийн хүсэлтийн дагуу шүүгчийн хараат бус байдалд халдсан этгээдэд хариуцлага хүлээлгэж шийдвэрлэсэн шүүгчийн захирамжид “нэхэмжлэгч шүүгчид хандаж гаргасан хүсэлтэд дурдсан зүйл нь ШТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй тул иргэнийг ШЭЗБТХ-ийн 38 дугаар зүйлийг 38.1.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож ” шийдвэрлэсэн байна.

Процесс зураглал №11



Хүснэгт №7 2017 онд хөтлөгдсөн нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт

№	Тоо	Нөлөөлсөн этгээд	Арга, хэлбэр	Шийдвэрлэсэн байгууллага	Шийдвэрийн нэр, үндэслэл	Авсан арга хэмжээ
1.	7	Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	Шууд /дарамтлах, заналхийлэх, гүтгэх доромжлох, шүүх хуралдааны явцад шүүгчийг загнах, дарамтлах, гүтгэх үйлдэл үзүүлсэн гэх/	Шүүхийн ерөнхий зөвлөл	Шүүх хуралдааны бичлэгээс үзэхэд ХИТ мэтгэлцэх зарчмын үүднээс шүүх хуралдаанд оролцсон үйлдэл нь ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчөөгүй.	Нөлөөлөх оролдлого хийсэн гэж үзэх үндэслэлгүй тухай шүүгчид хариу өгсөн.
2.		Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	Шууд /дарамтлах, заналхийлэх, гүтгэх доромжлох, шүүгчийг мөнгөтэй хүний эрхшээлд орсон гэж гүтгэсэн гэх/	Шүүхийн ерөнхий зөвлөл	Цугласан баримтаас үзэхэд ХИ төлөөлөгчийн үйлдэл нь ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчөөгүй, харин шүүхийг үл хүндэтгэсэн үйлдэл гаргасан гэж үзэхээр байна.	Нөлөөлөх оролдлого хийсэн гэж үзэх үндэслэлгүй тухай шүүгчид хариу өгсөн.
3.		Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	Шууд бус /дарамтлах, заналхийлэх, гүтгэх доромжлох, телевизийн нэвтрүүлэгт мөнгө хүүлэгчдийн талд орж авлига авсан мэтээр ярьсан /	Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	Шүүгчийн захирамж, "...телевизээр ярьсан зүйл нь ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн."	Торгох шийтгэл ногдуулсан.
4.		Хариуцагч	Шууд бус /гүтгэх доромжлох, шийдвэр гаргахдаа шударга бус, нэг талыг барьсан гэж гүтгэсэн гэх/	Шүүхийн ерөнхий зөвлөл	Цугласан баримтаас үзэхэд хариуцагчийн гаргасан гомдол нь ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй	Нөлөөлөх оролдлого хийсэн гэж үзэх үндэслэлгүй тухай шүүгчид

						хариу өгсөн.
5.	Өмгөөлөгч	Шууд бус/гүтгэж, доромжлох, шүүгч ялыг хүндрүүлж шийдсэн гэх ярилцлага өгсөн/	Шүүхийн ерөнхий зөвлөл	Цугласан баримтаас үзэхэд өмгөөлөгчийн үйлдэл ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй	Нөлөөлөх оролдлого хийсэн гэж үзэх үндэслэлгүй тухай шүүгчид хариу өгсөн.	
	Хариуцагч, өмгөөлөгч	Шууд /нөхцөл байдлыг тайлбарлах, дарамтлах заналхийлэх, шүүгчийн болон шүүгчийн туслахын ерөөнд орж хэргийн талаар ярьж, ёс зүйн хороонд өгнө гэсэн гэх/	Шүүхийн ерөнхий зөвлөл	Цугласан баримтаас үзэхэд өмгөөлөгчийн үйлдэл ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй	Нөлөөлөх оролдлого хийсэн гэж үзэх үндэслэлгүй тухай шүүгчид хариу өгсөн.	
6.	Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	Шууд бус гүтгэж, доромжлох, /шүүгчдийн талаар Улсын мөрдөн байцаах газрын тусгай субъектийн хэлтэст гаргасан гомдолдоо шүүгч нар хуульд заагдсан гэмт хэрэг үйлдэж, гэмт үйлдлээр луйвар хийж байна гээд гомдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргана гэсэн/ УДШ шүүх бүрэлдэхүүн	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Шүүгчийн захирамж “...ХИТ-ийн гаргасан гомдол нь ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн.”	Торгох шийтгэл ногдуулсан.	

2017 онд нийт 7 нөлөөллийн мэдүүлэг хөтлөгдөж ирснээс Шүүхийн ерөнхий зөвлөл 5 нөлөөллийн мэдүүлэгт “...цугласан баримтаас үзэхэд холбогдох этгээдийн үйлдэл нь ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн, нөлөөлөх оролдлого хийсэн гэж үзэх үндэслэлгүй” гэдгээр шүүгчид хариу хүргүүлж, шийдвэрлэсэн байна. Харин 2 нөлөөллийн мэдүүлгийг шүүхэд хүргүүлснийг шүүх хянаад холбогдох этгээдийн үйлдэл нь ШТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.3, ШЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасныг зөрчиж, шүүгчид нөлөөлсөн гэж үзэж, шийдвэрлэжээ.

▪ **Шүүхээр шийдвэрлэгдсэн мэдүүлэг /Хүснэгтийн 3, 7-т заасан/**

Тохиолдол №1

2 нөлөөллийн мэдүүлгийг ШЕЗ хүлээн авч, хянаад “...хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйлдлийг ШЕЗ-ийн 2017.05.25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд хэрэг

хянан шийдвэрлэх ажиллагааны явцад уг хэргийн шийдвэрлэлттэй холбогдуулан шүүх бүрэлдэхүүнд нөлөөлөх гэж оролдсон үйлдэл байж болзошгүй гэж үзэж” ШЭЗБТХ-ийн 38 дугаар зүйлд зааснаар холбогдох этгээдэд хариуцлага хүлээлгэх эсэх асуудлыг хянан, шийдвэрлүүлэхээр харьяалах шүүхэд хүргүүлсэн бол нэг мэдүүлгийг “хариуцсан итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйлдэл нь ШТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.3¹¹-д заасныг тус тус зөрчсөн гэх үндэслэлтэй” тул ШЭЗБТХ-ийн 38 дугаар зүйлд зааснаар холбогдох этгээдэд хариуцлага хүлээлгэх эсэх асуудлыг хянан шийдвэрлүүлэхээр харьяалах шүүхэд хүргүүлжээ.

Шүүхээс тус хоёр мэдүүлгийг хянаад “хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйлдэл нь ШТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.3, ШЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасныг тус тус зөрчиж шүүгчийг дарамтлах, заналхийлэх, доромжлох, гүтгэх хэлбэрээр нөлөөлсөн гэж үзэх үндэслэлтэй гэж үзэн ШЭЗБТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.1.1-д зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож” тус тус шийдвэрлэсэн байна.

Процесс зураглал №12



Хүснэгт №8 2018 онд хөтлөгдсөн нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт

№	Тоо	Нөлөөлсөн этгээд	Арга, хэлбэр	Шийдвэрлэсэн байгууллага	Шийдвэрийн нэр, үндэслэл	Авсан арга хэмжээ
1.	9	Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	Шууд /дарамтлах, заналхийлэх, гүтгэх доромжлох, шүүгчийг нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй танил, хувийн харилцаа холбоотой гэж гүтгэсэн гэх/	Шүүхийн ерөнхий зөвлөл	Цугласан баримтаас үзэхэд хариуцагчийн гаргасан үйлдэл ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй	Нөлөөлөх оролдлого хийсэн гэж үзэх үндэслэлгүй тухай шүүгчид хариу өгсөн.
2.		Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	Шууд бус /дарамтлах, заналхийлэх, гүтгэх доромжлох, шүүгч дэг сахиулах гэхэд муухай харж, маргах үйлдэл гаргадаг, чи хууль мэдэхгүй шүүгч, чамд итгэл төрөхгүй байна гэх мэтээр гүтгэж, доромжилсон гэх/	Шүүхийн ерөнхий зөвлөл	Цугласан баримтаас үзэхэд НИТ-ийн үйлдэл ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэхээргүй байна.	Нөлөөлөх оролдлого хийсэн гэж үзэх үндэслэлгүй тухай шүүгчид хариу өгсөн.
3.		Нэхэмжлэгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	Шууд /нөхцөл байдлыг тайлбарлах/	Шүүхийн ерөнхий зөвлөл	Цугласан баримтаас үзэхэд НИТ-ийн үйлдэл ШТХ-ийн 27.1 дэх	Нөлөөлөх оролдлого хийсэн гэж үзэх

¹¹ Шүүхийг үл хүндэтгэсэн, шүүн таслах ажиллагаанд саад учруулсан, шүүхийн шийдвэрийг үл биелүүлсэн, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шийдвэр гүйцэтгэгчийг гүтгэсэн гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэж, зөрчигдсэн эрх, нэр төрийг нь Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу сэргээнэ.

					хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэхээргүй байна.	үндэслэлгүй тухай шүүгчид хариу өгсөн.
4.	Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	Шууд /дарамтлах, заналхийлэх, гүтгэх доромжлох, шүүгчийг хэтэрхий нэг талыг барьсан, хууль буруу хэрэглэсэн гэж гүтгэж, доромжилсон гэх/	Шүүхийн ерөнхий зөвлөл		Цугласан баримтаас үзэхэд ХИТ-ийн үйлдэл ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй	Нөлөөлөх оролдлого хийсэн гэж үзэх үндэслэлгүй тухай шүүгчид хариу өгсөн.
5.	Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч	Шууд /Дарамтлах, заналхийлэх, шүүх бүрэлдэхүүнээс татгалзах хүсэлтийг хүлээн авахгүй бол шийдвэрийг олон нийтэд мэдээлнэ гэсэн гэх/ Шүүх бүрэлдэхүүн хөтөлсөн	Сум дундын шүүх		Шүүхийн шийтгэвэр төлөөлөгчийн гаргасан үйлдэл "ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн."	Торгох шийтгэл ногдуулсан. ДЗШШ-ээс анхан шатны шүүхийн шийтгэврийг хүчингүй болгосон.
6.	Нэхэмжлэгийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өмгөөлөгч	Шууд / дарамтлах, заналхийлэх, танай шүүх намайг залхааж, дарамталж байна. Ёс зүйн хороонд бичнэ гэсэн гэх/	 Шүүхийн ерөнхий зөвлөл		Цугласан баримтаас үзэхэд НИТ-ийн өмгөөлөгчийн үйлдэл ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй	Нөлөөлөх оролдлого хийсэн гэж үзэх үндэслэлгүй тухай шүүгчид хариу өгсөн.
7.	Гуравдагч итгээд	Шууд бус /гүтгэх доромжлох,... шүүгчийн ярьсныг эсрэгээр ашигласан гэх/	Шүүхийн ерөнхий зөвлөл		Цугласан баримтаас үзэхэд гуравдагч этгээдийн үйлдэл ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй	Нөлөөлөх оролдлого хийсэн гэж үзэх үндэслэлгүй тухай шүүгчид хариу өгсөн.
8.	Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	Шууд /дарамтлах, заналхийлэх, гүтгэх доромжлох, шүүгчийг хууль зөрчсөн шийдвэр гаргаж байна гэж үгээр дайрсан гэх/	Шүүхийн ерөнхий зөвлөл		Цугласан баримтаас үзэхэд ХИТ-ийн үйлдэл ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй, харин ИХШХШТ хуулийн 25.1.4-т заасан эрхээ эдэлсэн гэж үзэхээр байна.	Нөлөөлөх оролдлого хийсэн гэж үзэх үндэслэлгүй тухай шүүгчид хариу өгсөн.
9.	Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	Шууд бус /дарамтлах, заналхийлэх, гүтгэх доромжлох, шүүгч бусдын хөрөнгөд халджээ гэх нийтлэл бичсэн/	Шүүхийн ерөнхий зөвлөл		Цугласан баримтаас үзэхэд ХИТ-ийн үйлдэл ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй.	Нөлөөлөх оролдлого хийсэн гэж үзэх үндэслэлгүй тухай шүүгчид хариу өгсөн.


2018 онд 9 нөлөөллийн мэдүүлэг хөтлөгдөж ирснээс ШЕЗ 8 мэдүүлгийг “...цугласан баримтаас үзэхэд хариуцагчийн гаргасан үйлдэл ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй” гэдгээр шүүгчид хариу хүргүүлж, шийдвэрлэсэн бол 1 мэдүүлгийг шүүхэд шилжүүлснийг шүүх хянаад нөлөөлөхийг оролдсон гэх үндэслэлээр торгох шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ.

▪ **Шүүхээр шийдвэрлэгдсэн мэдүүлэг /Хүснэгтийн 5-т заасан/**

Тохиолдол №1

Харин нэг мэдүүлгийг хүлээн авч, танилцаад “хоширогчийн хууль ёсны төлөөлөгчийн үйлдэл нь ШТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасныг зөрчсөн гэх үндэслэлтэй тул ШЭЗБТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.2-т заасныг үндэслэн Зөрчлийн тухай хуулийн 15.4-д заасан хариуцлага хүлээлгэх эсэх асуудлыг хянан шийдвэрлүүлэх”-ээр харьяалах цагдаагийн газарт хүргүүлснийг тус газраас “...зөрчлийн хэрэгт бүртгэлийн ажиллагаа явуулж, шийтгэл ногдуулах” саналаа прокурорт шилжүүлснийг прокуророос “... тухайн этгээд Зөрчлийн тухай хуулийн 15.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөхийг оролдсон зөрчил үйлдсэн” гэсэн дүгнэлтээ харьяалах шүүхэд шилжүүлжээ. Сум дундын шүүхээс хянаад “ Зөрчлийн тухай хуулийн 15.4 хэсгийн 1 дэх хэсэгт заасныг баримтлан холбогдогч этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж” шийдвэрлэсэн байна.

Процесс зураглал №13



Хүснэгт №9 2019 онд хөтлөгдсөн нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт

№	Тоо	Нөлөөлсөн этгээд	Арга, хэлбэр	Шийдвэрлэсэн байгууллага	Шийдвэрийн нэр, үндэслэл	Авсан арга хэмжээ
1.	6	Нэхэмжлэгчийн танил	Шууд бус /шийдвэрийг урьдчилан хэлэлцэхийг санал болгох, шүүгчийн эхнэрээр дамжуулж нөлөөлөх гэж оролдсон гэх/	Шүүхийн ерөнхий зөвлөл	Гэр бүлийн хүнтэй утсаар ярьсан нь нөлөөллийн мэдүүлэг хөтлөх үйлдэлд хамаарахгүй.	Нөлөөлөх оролдлого хийсэн гэж үзэх үндэслэлгүй тухай шүүгчид хариу өгсөн.

Тайлбар: 2019 онд нийт 6 нөлөөллийн мэдүүлэг хөтлөгдөж ирснээс 1 мэдүүлэгт ШЕЗ хариу хүргүүлсэн, 5 мэдүүлэг “нөлөөллийн мэдүүлгийг шийдвэрлэх журам”-ын холбогдох заалт шүүхийн шийдвэрээр хүчингүй болсонтой холбоотойгоор ажиллагаа хийгдэх боломжгүй байна.

Хүснэгт №10 Нийт нөлөөллийн мэдүүлгийн шийдвэрлэлт /Байгууллагаар/

№	Үзүүлэлт	Шүүхийн ерөнхий зөвлөл		Цагдаа/АТГ	Прокурор	Шүүх
		Нийт	Шийдвэрлэсэн, холбогдох ажиллагаа хийгдсэн			
1	Мэдүүлгийн тоо		17	9	9	10
2	Шилжүүлсэн үндэслэл	41-36	18 мэдүүлгийг ШТХ-ийн 27.1-д заасныг зөрчсөн гэх үндэслэл (агуулгаар) шилжүүлсэн. 1 тохиолдолд гэмт хэргийн	Цагдаа (7) эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, 1 тохиолдолд шүүхэд шилжүүлсэн, АТГ(1) эрүүгийн	-	-

			шинжтэй гэж үзэж, шилжүүлсэн.	хэрэг үүсгэх саналтай		
3	Шийдвэрийн үндэслэл		17 мэдүүлгийг ШТХ-ийн 27.1-д заасныг зөрчсөн гэх үндэслэлгүй гэдгээр шүүгчид хариу хүргүүлсэн.	-	Эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлгүй тул ЭБШХ-ийн 175 дугаар зүйлийг үндэслэн эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	ШТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй тул ШЭЗБТХ-ийн 38.1.1-т заасны дагуу торгох шийтгэл ногдуулсан.

ХОЁР. ШҮҮГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН


Энэхүү судалгаанд анхан болон давж заалдах шатны 27 шүүхийн 132 шүүгч хамрагдсан. Шүүгчдийн асуулгад хариулсан байдалд үндэслэн судалгааны үр дүнг тооцлоо. Судлаачийн хувийн үзэл бодол тусгагдаагүй болно.

2015 онд Нээлттэй нийгэм форум ТББ-аас явуулсан “Шүүгчийн хараат бус байдлын баталгаа, хэрэгжилт” бодлогын судалгаанд хамрагдсан 11 жил ажилласан нэг шүүгч “Нөлөөллийн мэдүүлэг бүх талын нөлөөллийг хангалттай хамарч хязгаарлаж чадахгүй байна. Цаана нь шүүгчид итгэл хүлээлгэж байгаа. Шүүгч нь нөлөөлөхийг оролдсон, (авлига) өгье гэсэн хүнээ өгөх боломжтой. Нөлөөлөх гэж байгаа этгээдийг гаргаад тавихад цаад хүн нь өөрөө шүүгчийг ажилгүй болгохоор эрх хэмжээний хүн байвал 10 шүүгч байхад хэд нь тэрийг нөлөөллийн мэдүүлэгт бичих вэ гэдэг өөрөө асуултын тэмдэг.”¹² гэж ярьсан нь энэхүү судалгааг шүүгчдээс авч нэгтгэх хүртэлх хугацаанд эргэлзээ төрүүлж байсан юм.

2.1. Шүүгчдийн хүн ам зүйн байдал

Судалгаанд хамрагдсан нийт 132 шүүгчийн 37 хувь нь эрэгтэй, 63 хувь эмэгтэй, 24 хувь нь 30-40, 42 хувь нь 41-50, 20 хувь 50 дээш настай, 14 хувь насаа нууцалсан, шүүхийн төрлийн хувьд 39 хувь эрүү, 34 хувь нь иргэн, 27 хувь нь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, 1 хүртэлх болон 1-3 жил ажилласан 7 шүүгч, 4-6 жил 26, 7-10 жил 13, 86 буюу 65 хувь нь 10 дээш жил ажилласан шүүгч байна.

Зураг №4 Судалгаанд хамрагдсан шүүгчдийн хүн ам зүйн байдал




¹² Нээлттэй нийгэм форум. Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь сэдэвт хэлэлцүүлэг, судалгааны эмхэтгэл. УБ.,2015, “Шүүгчийн хараат бус байдлын баталгаа, хэрэгжилт” бодлогын судалгааны тайлан, 34 дэх тал.

Судалгаанд хамрагдсан шүүгчдийн 30 буюу 23 хувь нь өмнө нь нөлөөллийн мэдүүлэг хөтөлж байсан бол 77 хувь нь хөтөлж байгаагүй шүүгчид байна. Энэ нь 2013-2019 оны хооронд нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн 51 шүүгчийн 58 хувь нь энэхүү судалгаанд хамрагдсан байна.

Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх талаарх ойлголт маш сайн 26, сайн 82, дунд зэрэг 22, муу 2 шүүгч байна. Энэ нь судалгаанд хамрагдсан нийт шүүгчдийн 108 буюу 82 хувь нь нөлөөллийн мэдүүлгийн талаар ойлголт сайтай гэсэн үг юм.

Зураг №5 Судалгаанд хамрагдсан шүүгчдийн нөлөөллийн мэдүүлгийн талаарх ойлголт, хөтөлсөн байдал



2.2. Судалгааны асуулгад хариулсан байдал

Шүүн таслах ажиллагаа явуулахад Танд хэн этгээдээс аль нэг хэлбэрээр нөлөөлөх гэж оролдож байсан уу гэсэн асуултад судалгаанд хамрагдсан шүүгчдийн 57 буюу 43 хувь нь тийм, 67 буюу 51 хувь нь үгүй, 8 буюу 6 хувь нь санахгүй байна гэж хариулсан. Судалгаанд харагдсан шүүгчийн 30 нь өмнө нөлөөллийн мэдүүлэг хөтөлж, ШЕЗ-д ирүүлсэн бол 27 шүүгч аливаа этгээдээс үзүүлсэн нөлөөлөх оролдлогод нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй байна.

Нөлөөллийн арга, хэрэгсэл шууд 20, шууд бус 21 буюу ойролцоогоор 50х50 хувьтай байгаа бол хэлбэрийн хувьд хээл хахууль, шан харамж, бэлэг сэлт өгөхийг завдах 3, дарамт шахалт үзүүлэх 18, дарамтлах, заналхийлэх 14, доромжлох, гүтгэх 25, шүүгчийн бие, орон байр, унааны аюулгүй байдалд халдах 7, шийдвэрийг урьдчилан хэлэлцэхийг санал болгох 2, шийдвэрийн талаар урьдчилан зааварчилгаа өгөх 12, нөхцөл байдлыг тайлбарлах 26, бусад хэрэг, маргааны шийдвэрийг жишиг болгохыг санал болгох 16 буюу Нөлөөллийн мэдүүлэг шийдвэрлэх журамд заасан нөлөөллийн 10 хэлбэрээс шүүгч болон гэр бүлийн гишүүдэд албан тушаал санал болгохоос бусад хэлбэрээр нөлөөлөх оролдлого үзүүлсэн байна. Бусад хэлбэр гэсэн сонголт дээр шүүгчид “шийдвэрлэгдээгүй хэрэг дээр болон үндэслэлгүйгээр Ёс зүйн хороонд гомдол гаргаж хандаж байсан, албан тушаалаа ашиглан нөлөөлөхийг оролдох, үндэслэлгүйгээр татгалзах, үг хэл амаар доромжлох” зэргийг бичсэн.

Хүснэгт №11 Нөлөөлөх оролдлого үзүүлсэн хэлбэр /тоо, хэмжээ/

№	Танд ямар хэлбэрээр нөлөөлөх гэж оролдож байсан бэ? /хэд хэдэн сонголтоор бөглөх боломжтой/	Хариулт	
		Тоо	Хувь
1.	а. Хээл хахууль, шан харамж, бэлэг сэлт өгөхийг завдах	3	3
2.	б. Шүүгч болон гэр бүлийн гишүүдэд албан тушаал санал болгох	-	-
3.	в. Дарамт шахалт үзүүлэх	18	17
4.	г. Дарамтлах, заналхийлэх	14	13
5.	д. Доромжлох, гүтгэх	25	23
6.	е. Шүүгчийн бие, орон байр, унааны аюулгүй байдалд халдах	7	7
7.	ё. Шийдвэрийг урьдчилан хэлэлцэхийг санал болгох	2	2
8.	ж. Шийдвэрийн талаар урьдчилан зааварчилгаа өгөх	12	11
9.	з. Нөхцөл байдлыг тайлбарлах	26	24
Нийт		107	100

Тайлбар: Хэд хэдэн сонголттой харилтын хувилбараар

Судалгаанд оролцсон шүүгчдийн 57 нь шүүн таслах ажиллагаа явуулахад хэн этгээдээс нөлөөлөх гэж оролдож байсан гэж хариулсан ба давхардсан тоогоор 107 хэлбэрээр нөлөөлөх оролдлого үзүүлсэн гэж үзсэн байна. Үүнээс дарамт шахалт үзүүлэх, дарамтлах, заналхийлэх, доромжлох, гүтгэх үйлдэл 49.5¹³ хувийг, шийдвэрийн талаар урьдчилсан зааварчилгаа өгөх, нөхцөл байдлыг тайлбарлах үйлдэл 33 хувийг эзэлж байна. Харин хээл хахууль, шан харамж, бэлэг сэлт өгөхийг завдах тохиолдол 3 гарсан ба 2013-2019 онд энэхүү үйлдэлд 1 удаа нөлөөллийн мэдүүлэг хөтлөгдсөн нь 2 тохиолдолд шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй гэсэн үг юм. Мөн дээрх хугацаанд дарамт шахалт үзүүлэх хэлбэрээр нөлөөлөхийг оролдсон 4 тохиолдолд мэдүүлэг хөтөлж ирүүлсэн бол судалгаанд хамрагдсан шүүгчдээс 18 нь дарамт шахалт үзүүлэх хэлбэрээр нөлөөлөхийг оролддог гэжээ. Энэ нь дээрх хугацаанд дарамт шахалт үзүүлэх хэлбэрээр нөлөөлөхийг оролдсон 14 тохиолдолд шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй байна.


Өөрөөр хэлбэл шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлөхийг оролдсон үйлдэл бүрд нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй нь судалгааны үр дүн болон 2013-2019 онд ШЕЗ-д шүүгчээс хөтлөн ирүүлсэн мэдүүлгийн харьцуулсан үзүүлэлтээс харагдаж байна.

Хүснэгт №12 Нөлөөлөх оролдлого үзүүлсэн тохиолдол /харьцуулалт/

№	Нөлөөллийн хэлбэр	Харьцуулалт		
		Шүүгчдийн хариулт	2013-2019 онд НМ хөтөлсөн тохиолдол	Нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй тохиолдол
1.	Хээл хахууль, шан харамж, бэлэг сэлт өгөхийг завдах	3	1	2
2.	Шүүгч болон гэр бүлийн гишүүдэд албан тушаал санал болгох	-	-	-
3.	Дарамт шахалт үзүүлэх	18	4	14
4.	Дарамтлах, заналхийлэх	14	26	-12
5.	Доромжлох, гүтгэх	25	25	-
6.	Шүүгчийн бие, орон байр, унааны аюулгүй байдалд халдах	7	-	7
7.	Шийдвэрийг урьдчилан хэлэлцэхийг санал болгох	2	5	-3
8.	Шийдвэрийн талаар урьдчилан зааварчилгаа өгөх	12	-	12
9.	Нөхцөл байдлыг тайлбарлах	26	3	23
Нийт		107	64	58

¹³ 2013-2019 онд нөлөөллийн мэдүүлэг хөтлөгдсөн 64 хэлбэрийн 51 нь дарамтлах, заналхийлэх, доромжлох, гүтгэх үйлдэл байсан.

Зураг №6 Судалгаанд хамрагдсан шүүгчдийн нөлөөллийн мэдүүлгийн талаарх ойлголт, хөтөлсөн байдал /харьцуулалт/



Хэрэг маргааны шийдвэрлэлттэй холбогдуулан Танд нөлөөлөх оролдлого үзүүлж байсан этгээд аль нь вэ гэсэн хэд хэдэн сонголттой хариултын хувилбартай асуулгад 57 шүүгчийн 33 нь хэргийн оролцогч, 32 улс төрийн албан тушаалтан, өмгөөлөгч гэж хариулсан нь олонх байна. Харин томилох эрх бүхий албан тушаалтан 4, дээд шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч 12, Шүүхийн ерөнхий зөвлөл 4 гэж хариулсан нь анхаарал татаж байгаа юм.

Зураг №7 Нөлөөлөх оролдлого үзүүлсэн этгээд




Судалгааны дүнгээс үзэхэд өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хэргийн оролцогч нарын үйлдэлд нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг, харин нөлөө бүхий албан тушаалтны үйлдэлд мэдүүлэг хөтөлдөггүй байна.

Танд нөлөөлөх гэж оролдсон этгээдийн үйлдэлд мэдүүлэг хөтлөөгүй шалтгаан юу вэ гэсэн хэд хэдэн сонголттой асуулгад дээрх шүүгчдийн 17 нь нөлөөллийн мэдүүлэг хөтөлснөөр ирж болох дарамт шахалтаас эмээдэг гэж хариулсныг анхаарууштай.

Ажлын ачаалал их, журамд заасан ажиллагааг хийхэд төвөгтэй /тайлбар гаргах, мэдүүлэг өгөх/ гэж хариулсан нь давхардсан тоогоор 42 шүүгч, нөлөөллийн мэдүүлгийн хэлбэрт бүх талын нөлөөлөл тусгагдаагүй гэсэн 16, танил тал татдаг 5, мэдүүлэг хөтлөх талаарх ойлголт муу 1, шалтгаан байхгүй гэж хариулсан 3 шүүгч тус тус байна.


Харин бусад хэсэгт мэдүүлэг хөтлөх хэмжээний нөлөөлөл биш гэж үздэг, тухайн хэргийн оролцогчийн эрх юм, оролдлого үзүүлсэн этгээдэд нөлөөллийн мэдүүлгийн талаар сануулахад дахин ийм асуудал гаргахгүй гэсэн, тухайн байгууллагын удирдлагад мэдэгдсэн, тухайн үеийн хуульд байгаагүй, нөлөөлөл гэж бодоогүй, шаардлагагүй гэж үзсэн, байнга л сахилгын хороо, АТГ-д өгнө гэдэг шүү дээ, өөрт нь хэлснээр үйлдлээ шууд зогсоосон тул зэргээр мэдүүлэг хөтлөөгүй шалтгаанаа бичжээ.

Зураг №8 Нөлөөлөх оролдлогод мэдүүлэг хөтлөөгүй шалтгаан



Монгол Улсад шүүгчийн хараат бус байдал хэр зэрэг хангагдсан гэж үздэг вэ гэсэн асуулгад судалгаанд хамрагдсан нийт 132 шүүгчийн 79 буюу 60 хувь нь дунд зэрэг, 43 буюу 33 хувь нь муу, хангагдаагүй гэж үзсэн бол 10 буюу 7.5 хувь нь л “сайн” гэж хариулжээ.

Зураг №9 Шүүгчийн хараат бус байдлын талаарх шүүгчдийн үнэлгээ



Харин шүүгчийн хараат бус байдлыг хангахад ямар хүчин зүйл чухал нөлөөтэй гэж үздэг талаарх асуулгад шүүгчид дараах байдлаар хариулсан байна.


Хүснэгт №13 Шүүгчийн хараат бус байдлыг хангахад нөлөөлөх хүчин зүйл

№	Та шүүгчийн хараат бус байдлыг хангахад ямар хүчин зүйл чухал нөлөөтэй гэж үздэг вэ? /хэд хэдэн сонголттой боломжтой/	Хариулт	
		Тоо	Хувь
1.	а. Эдийн засгийн баталгаа	50+62	85
2.	б. Хууль зүйн баталгаа	51+62	86
3.	в. Томилгооны хараат бус байдал	29+62	69
4.	г. Шүүгчийн өөрийнх нь ёс зүй, мэдлэг мэргэшил, ур чадвар	28+62	68
5.	д. Дээрх бүгд	62	47
6.	е. Мэдэхгүй	-	-

Тайлбар: Хэд хэдэн сонголттой харилтын хувилбараар


Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх хэлбэр шүүгчийн хараат бус байдлыг хангахад хэр үр нөлөөтэй талаар судалгаанд хамрагдсан нийт шүүгчдийн 53 хувь нь сайн гэж үзсэн бол муу, үр дүн гараагүй гэж 17 хувь нь хариулжээ.

Зураг №10 Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх үр нөлөө



Харин шүүгч хараат бус, нөлөөллөөс ангид байх нь шүүгчээс өөрөөс нь хамааралтай гэсэн асуулгад судалгаанд оролцсон шүүгчийн 96 хувь нь санал нийлдэг гэсэн юм.

Зураг №11 Шүүгчийн хараат бус байдлыг хангахад шүүгчийн оролцоо



Шүүгчдээс өөрсдийн хянан шийдвэрлэж буй хэргийн талаар санал солилцох, урьдчилан хэлэлцэх, зааварчилгаа өгөх зэргээр хоорондоо харилцдаг эсэхийг тандахад заримдаа хэргийн ээдрээ төвөгтэй байдлаас шалтгаалж, мөн ажил хэргийн хувьд хандах

шаардлага гардаг гэж шүүгчдийн 71 хувь, хандах шаардлага гардаггүй гэж 30 хувь нь үзсэн байна.

Мөн шүүгчид тухайн хэрэг маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар шүүгч, Ерөнхий шүүгчээс зааварчилгаа өгдөг тохиолдол байдаг эсэхийг асуухад байдаг гэсэн 6, зааварчилгаа биш зөвлөгөө өгөх тохиолдол байдаг гэж 27, байдаггүй, тийм зүйл байх ёсгүй гэж 99 шүүгчид хариулсан юм.

Судалгааны сүүлчийн асуулгаар “Нөлөөллийн мэдүүлэг шийдвэрлэх журам”-ын хэрэгжилтийг сайжруулахад ямар хүчин зүйл үр нөлөөтэй болохыг шүүгчдээс хэд хэдэн сонголттой хариултын хувилбараар асуухад 63 шүүгч нөлөөллийн мэдүүлгийн талаарх сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах, 83 нь журмыг шинэчлэх /процессын ажиллагааг тодорхой заах, нөлөөлөх хэлбэрийн талаар албан ёсны тайлбар гаргуулах/, 79 нь хөтөлсөн мэдүүлгийн нууцлалыг нууцын журмаар хангах, 51 нь нөлөөлсөн тухай мэдээллийг хуульд заасан хугацаанд олон нийтэд мэдээлэх, 50 нь журмын хэрэгжилтийг сайжруулах чиглэлд захиргааны хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх, 46 нь төрийн байгууллагуудын хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах хүрээнд тодорхой арга хэмжээ авах, бусад чиглэлд иргэдэд сурталчлах, хөтөлсөн мэдүүлэг ШЕЗ холбогдох арга хэмжээ авдаггүй нь мэдүүлгийг хүлээн авч хянаж байгаа албан тушаалтны үзэмжээр шийдвэрлэгддэг гэж ойлгосон тул заавал шалгаж байх ёстой, хурдан хугацаанд шийдвэрлэгддэг болох, нөлөөллийн мэдүүлэг тийм ч үр дүнтэй биш шүүгчийн өөрийнх нь мэдлэг ур чадвар, ёс зүй л чухал гэж үзсэн байна.

Хүснэгт №14 Шүүгчийн хараат бус байдлыг хангахад цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Та шүүгчийн хараат бус байдлыг хангахад ямар хүчин зүйл чухал нөлөөтэй гэж үздэг вэ? /хэд хэдэн сонголтоор бөглөх боломжтой/	Хариулт	
		Тоо	Хувь
1.	а.Шүүгчдэд нөлөөллийн мэдүүлгийн талаарх сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах	35+28	48
2.	б.Журмыг шинэчлэх, /процессын ажиллагааг тодорхой заах, нөлөөлөх хэлбэрийн талаар албан ёсны тайлбар гаргуулах/	55+28	63
3.	в.Хөтөлсөн мэдүүлгийн нууцлалыг нууцын журмаар хангах	51+28	60
4.	г.Нөлөөлсөн тухай мэдээллийг хуульд заасан хугацаанд олон нийтэд мэдээлэх	23+28	39
5.	д. Журмын хэрэгжилтийг сайжруулах чиглэлд захиргааны хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх	22+28	47
6.	е.Төрийн байгууллагуудын хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах хүрээнд тодорхой арга хэмжээ авах	18+28	38
7.	ё.Дээрх бүгд	28	21
8.	ж.Бусад.....-ыг бичнэ үү.	5	3.7

Тайлбар: Хэд хэдэн сонголттой харилтын хувилбараар

ГУРАВ. ШҮҮГЧ ХАРААТ БУС, НӨЛӨӨЛЛӨӨС АНГИД БАЙХ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН СУУРЬ ЗАРЧИМ, ГАДААД УЛСЫН ТУРШЛАГА

“Үндсэн хуульд шүүх эрх мэдэл хэрхэн туссаныг иргэд олон нийт ойлгож, ухамсарлаагүй цагт шүүхийн хараат бус байдалд аюул учирдаг”¹⁴
АНУ-ын Дээд шүүхийн шүүгч Дэвид Сүүгэр (1992)

3.1. Шүүгчийн хараат бус байдлын зарчим, ангилал, баталгаа

Олон Улсын хэмжээнд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хуулийн засаглалын суурь нөхцөл (Европын зөвлөл 1998, Нэгдсэн Үндэстний байгууллага 1985) гэж үздэг¹⁵ ба албаны (Institutional Independence), болон хувийн (Personal Independence) гэсэн хоёр¹⁶ хэсэгт хувааж үздэг байна.

Шүүгчийн албаны хараат бус байдал хангагдсан байх нь төрөөс, харин хувийн хараат бус байдлаа хангах нь шүүгчээс өөрөөс нь голчлон хамаардаг¹⁷ гэж үздэг. Албаны хараат бус байдалд шүүгч шүүн таслах ажиллагааг бие даан хэрэгжүүлэх, шийдвэр гаргах хууль зүйн болон эдийн засгийн цогц баталгаа бүрдсэн байхыг, хувийн хараат бус байдалд албан тушаалын нэр хүндээ ухамсарласан байдал, шүүгчийн өөрийн мэргэжлийн ур чадвар, мэргэшлийн ёс зүй, биеэ авч явах, аливаа этгээдээс хараат бусаар шийдвэр гаргах бие даасан байдал, хувь хүний хөгжлийн хандлага зэрэг олон хүчин зүйлийг хамааруулж ойлгодог.

Ер нь яагаад шүүгчийн хараат бус байдал чухал талаар “Шүүгч хэргийг шүүхэд ирүүлсэн нотлох баримтад үндэслэн хуульд заасны дагуу шийдвэрлэх боломжтой байх нь хамгийн чухал юм. Зөвхөн нотлох баримт болон хууль л шүүгчийн шийдвэрийн үндэс байх ёстой. Зөвхөн ийм л байдлаар шүүгчид шударга ёсыг хангах үндсэн хуулийн үүргээ гүйцэтгэж чадна. Иргэд, төр хоорондын маргааныг хянан шийдвэрлэх шүүгчдийн үүрэг хариуцлага засгийн газрын чиг үүргийн өсөлттэй зэрэгцэн нэмэгдсэн. Иймд иргэдийг засгийн газрын хууль бус шийдвэрээс хамгаалах шүүхийн үүрэг хариуцлага нэмэгдэж, үүний зэрэгцээ шүүх засаглал хараат бус байх шаардлага тулгарч байна”¹⁸ гэжээ.

Дэлхийн улс орнууд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах ёстой гэдэг хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, нэгдсэн зарчим, ойлголтод хүрсэн, харин хараат бус байдлыг хэнээс, хэнийг, яаж хамгаалах вэ гэдэг асуудал дээр өөр өөрсдийн онцлогт тохирсон арга хэлбэрийг хэрэглэж байна.

Энэ талаар “Шүүх гаднын ямар нэг нөлөөгүй, дарамт шахалтгүй зөвхөн хуульд нийцүүлэн хэрэг маргааныг шийдэж байх ёстойг НҮБ-ын зарчимд заасан. Мэдээж үүнийг хэрэгжүүлэх механизмыг улс бүр өөр өөрийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлнэ. Манай улс¹⁹ энэ зарчмыг Үндсэн хуулийнхаа Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд нь хэн ч оролцож болохгүй гэж 27 жилийн тэрдээ заасан ч хэр зэрэг хязгаарласныг олон түмэн мэднэ. Ийм тунхаг нэмэргүй гэдгийг бид хүлээн зөвшөөрч шүүхийн тухай багц хуулиар түүнийг хэрэгжүүлэх процессыг зохицуулахыг оролдож,

¹⁴ Н.Лүндэндорж, Шүүх эрх мэдэл, УБ.,2017, 9 дэх тал.

¹⁵ ННФ, Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь: сэдэвт хэлэлцүүлэг, судалгааны эмхэтгэл, УБ.,2015, 2 дугаар судалгааны 6 дахь талд.

¹⁶ ШЕЗ, Шүүх эрх мэдэл, УБ.,2014, №2, 52 дахь тал, судлаач С.Билгүүн, Шүүхийн хараат бус байдал өгүүллэгээс дэлгэргүйг үзнэ үү.

¹⁷ Н Лүндэндорж, Шүүх эрх мэдэл, УБ.,2017, 87 дахь талд бичсэнийг дэлгэрүүлж бичсэн.

¹⁸<https://www.judiciary.uk/about-the-judiciary/the-judiciary-the-government-and-the-constitution/jud-acc-ind/independence/>

¹⁹ Монгол улсыг хэлсэн.

нөлөөллийн мэдүүлэг хөтлөх механизмыг нэвтрүүлж, шүүгчид нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх дажгүй сайн механизмыг бүрдүүлсэн хэдий ч 2016 онд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 38 дугаар зүйлийг Зөрчлийн тухай хууль тогтоомж батлахтай холбогдуулан хүчингүй болгохоор шийдсэнээр шүүгчид нөлөөлөх үүд хаалгаа дахин “нээсэн” билээ. Эндээс сургамж авах ёстой. Үндсэн хуулиас бусад хуульд ямар ч сайн зохицуулалт оруулаад нэмэргүй, нэг л нартай өдөр арилгаж болдог гэдгийг ямагт санах нь чухал”²⁰ гэжээ.

Мөн ардчилсан улсын хувьд бие даасан шүүх засаглал, хараат бус шүүгч гаднын аливаа дарамт шахалт ангид байж, хуульд захирагдан хэрэг маргааныг шударгаар шийдвэрлэх нь олон нийт шүүхэд итгэх итгэл үнэмшилтэй байна. Шүүгч үүргээ гүйцэтгэхдээ ямар нэгэн зохисгүй нөлөөллөөс ангид байх ёстой. Ийм нөлөө нь олон тооны эх сурвалжаас ирж болно. Энэ нь гүйцэтгэх засаглал буюу хууль тогтоох байгууллага, хэргийн оролцогч, эсхүл тодорхой дарамт шахалтын бүлэг, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, шүүгчийн өөрийн хувийн сонирхол болон бусад шүүгчид, ялангуяа илүү ахмад шүүгчдийн дарамт шахалтаас үүдэлтэй байж болно²¹ гэсэн байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллага болон Европын зөвлөлөөс гаргасан шүүгчийн хараат бус байдлын талаарх зарчим, тунхаглалд шүүгчийн хараат бус байдлыг шүүгч аливаа дарамт, нөлөөллөөс ангид байж зөвхөн хуульд нийцүүлэн (захирагдан) шийдвэр гаргах нөхцөл боломжоор хангагдсан байхаар нийтлэгээр тодорхойлжээ.

Дээрх байгууллагуудаас шүүхийн бие даасан шалгуур үзүүлэлт, хараат бус байдалд нөлөөлөх нийтлэг хүчин зүйлийг боловсруулахдаа шүүгчийн бүрэн эрхийн хугацаа, хараат бус байдал, нийгмийн болон эдийн засгийн баталгаа, албан тушаал дэвших горим журам зэрэгтэй холбоотой зарчмуудыг оруулсан байна.²²

НҮБ-ийн зарчимд “Шүүх эрх мэдлийн хараат бус, бие даасан байдлыг Үндсэн хуулиар болон бусад хуулиар баталгаажуулах, засаг төрийн бүх байгууллага шүүхийн хараат бус байдлыг хүндэтгэж байх үүрэгтэйг зааж өгсөн²³” Мөн тэнд дараах зарчмуудыг зааж өгсөн байна. Үүнд, 1.Шүүх гаднын ямар нэг нөлөөгүй, дарамт шахалтгүй зөвхөн хуульд нийцүүлэн хэрэг маргааныг шийдэх ёстой, 2.шүүх чиг үүргээ өөрөө тогтоох чиг үүрэгтэй байх ёстой, 3. Шүүхийн шийдвэрийг хэн ч өөрчлөх ёсгүй, 5.Шүүх хүртээмжтэй байх буюу иргэд шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх эрхийг хангах, 6.Шүүхийн хараат бус байдлын зарчим, 7. Шүүгч үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөтэй байх /үүнийг шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал, шударга байдлыг хангахын төлөө илэрхийлбэл зохимжтой гэж үздэг/ зэргээр цааш сонгон шалгаруулах, шүүгчийн ажиллах нөхцөл, бүрэн эрхийн хугацаа, нийгмийн баталгаа, халдашгүй байдал, ёс зүй, сахилга хариуцлагын асуудлаар зарчим үргэлжилнэ.

Харин шүүгчийн ажил, шударга ёсны үйлчилгээний чанарыг үнэлэх, шүүхийн хараат бус байдлыг хүндэтгэх талаарх Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн 2014 оны 17 дугаар зөвлөмжид “...Шүүхийн хараат бус байдал нь шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоход төдийгүй, ерөнхий шүүгч, бусад шүүгчдийн

²⁰ Мөн тэнд. 14 дэх талд.

²¹<https://www.judiciary.uk/about-the-judiciary/the-judiciary-the-government-and-the-constitution/jud-acc-ind/independence/>

²² ННФ, Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь: сэдэвт хэлэлцүүлэг, судалгааны эмхэтгэл, УБ.,2015, 2-р судалгааны 8 дахь талаас дэлгэрэнгүйг үзнэ үү.

²³ Н.Лүндэндорж, Шүүх эрх мэдэл, УБ.,2017, 12 дахь тал.

нөлөөнөөс ангид байх тухай ойлголт юм”²⁴ гэдгийг зааж өгсөн бол шүүхийн хараат бус байдлын талаарх Монреалын тунхаглалын 2 дугаар зүйлийн 2.02-т “Шүүгч нь хараат бус байх бөгөөд ирсэн хэрэг маргааныг хөндлөнгийн элдэв шууд болон шууд бус хязгаарлалт, нөлөөлөл, айдас, дарамт шахалт, заналхийлэл, оролцоогүйгээр гагцхүү үйл баримтыг үнэлэн хуулийг хэрэглэж төвч байдлаар шийдвэрлэнэ”, 2.03-т “Шүүгчид нь шийдвэр гаргах явцдаа хамт ажилладаг бусад шүүгч, дээд шатны шүүхийн шүүгчдээс хараат бус байна. Шүүхийн байгууллагын дотоодын аливаа тогтолцоо, шатлал, эрэмбийн зөрүү нь шүүгч хараат бусаар шийдвэрээ гаргахад нөлөөлөх ёсгүй”, 2.08-д “Хууль тогтоох болон гүйцэтгэх байгууллагын аливаа шийдвэр, захирамжаар тодорхой шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх, шийдвэр гаргахад нь нөлөөлөхийн тулд шүүхийн бүрэлдэхүүнийг өөрчилж болохгүй”²⁵ гэжээ.

Мөн Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн 2001 оны 1 дүгээр зөвлөмжийн 10-т “Шүүгчийн хараат бус байдал бол шударга шүүхийн үндсэн баталгаа бөгөөд эрх зүйт төрийн урьдач нөхцөл юм. Хараат бус байдал нь шүүгчдэд дур зоргоороо авирлах онцгой эрх олгож байгаа хэрэг бус, харин эрх ёсны ашиг сонирхлын үүднээс шударга ёсыг эрэлхийлэх, түүнийг шаардах баталгааг өгч буй явдал юм.” 12-т “шүүхийн хараат бус байдлын урьдач нөхцөл нь шүүгч төвийг сахисан байхаас эхэлнэ. Шүүгч талуудын хоорондын маргааныг шийдвэрлэхдээ хөндлөнгийн байр сууриас хандаж, бүрэн хараат бус шийдвэр гаргах чадамжид нь саад болох, эсхүл саад болж болзошгүй бүхий л харилцаа холбоо, ашиг сонирхол болон хандлагаас ангид байна. “Хэн ч өөрийнхөө асуудалд шүүгч байж болохгүй” гэсэн зарчмаас шүүгчийн хараат бус байдлын санаа үүдэн гардаг. Энэхүү зарчим зөвхөн маргааны талуудаас хальж давж гарах ач холбогдолтой. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа талууд төдийгүй нийгэм шүүхийн тогтолцоонд итгэх ёстой. Шүүхийн хараат бус байдлыг алдагдуулахгүйн тулд шүүгч нь өөрийнхөө хувьд зүй бус харилцаа холбоо, нөлөө, ялгаварлан гадуурхалтаас ангид байх төдийгүй энгийн ажиглагч нэгэнд тийнхүү ойлгогдох ёстой юм.”²⁶ гэсэн байна.

Дээрх зарчмын хүрээнд үндсэн хуульд тусгасан шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа (хууль зүйн, эдийн засгийн...) -нд хэн боловч хүндэтгэлтэй хандах, түүнийг ухамсарласан байдлаар нь тухайн улсын шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг үнэлдэг байна. Өөрөөр хэлбэл улс орнуудад шүүгчийн хараат бус байдал, шүүхийн бие даасан байдлын хэрэгжилтийг үнэлэхдээ дээрх баримт бичиг болон суурь зарчмуудад тулгуурлан олон төрлийн шалгуурыг үндэслэл болгон авч үздэг ба үүнд зөвхөн шүүхийн төсөв санхүү, сонгон шалгаруулалт, алба хаах хугацаа зэрэг хуулийн зохицуулалт, техникийн үзүүлэлтүүдийг голлон харгалзах нь хангалтгүй²⁷ гэжээ.

Иймд гаднын зарим улсад шүүгчийг хэн нэгэн этгээдийн нөлөөллөөс хамгаалах тухай биш харин шүүгчийг өөрөөс нь хамгаалах тухай, шийдвэр гаргахад нөлөөлж болзошгүй ахуйн болон орчны, цаг уурын нөхцөл байдлаас хамгаалах тухай асуудлыг тавьж байгаа нь дээрх суурь зарчмын хүрээнд шүүгчийн хараат бус хангагдсан, шүүгчид нөлөөлөх ёсгүй гэсэн нийгмийн ухамсар төлөвшсөн байна.

²⁴ ШЕЗ, Шүүхийн хараат бус байдал. Олон улсын баримт бичиг, УБ.,2019, 206 дахь тал.

²⁵ ШЕЗ, Шүүхийн хараат бус байдал. Олон улсын баримт бичиг, УБ.,2019, 274 дахь тал.

²⁶ Мөн тэнд. 16 дахь тал.

²⁷ ННФ, Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь: сэдэвт хэлэлцүүлэг, судалгааны эмхэтгэл, УБ.,2015, 2-р судалгааны 8 дахь тал.

Олон улсын баримт бичгүүд болон Банглорын зарчмын жишгийг үндэс болговол шүүхийн хараат бус байдал дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд,²⁸

1) шүүх нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэлтэй ижил эрх зүйн байдалтай төрийн бие даасан эрх мэдэл;

2) хараат бус байдлаа хадгалахын тулд шүүх нь бодлогоо өөрөө тодорхойлно;

3) шүүхийн төсвийг өөрсдөө боловсруулж, батлуулахаар парламентад оруулна;

4) шүүгч нарыг томилох буюу сонгох, дэвшүүлэх журам нь ил тод, тодорхой байх;

5) шүүгч нарыг бүх насаар нь томилох;

4) шүүгч нарын цалин нь амьдралд хүрэлцээтэй байх;

6) шүүгч нар боловсрол, туршлагын хувь наад захын өндөр шаардлага хангасан байх;

7) шүүгчийг дэвшүүлэх нь түүний мэргэжлийн мэдлэг, туршлага, ёс зүйн чанарыг бодитоор үнэлсний үндсэн дээр хийгдэх;

8) шүүгчид сахилгын арга хэмжээ ногдуулах буюу огцруулах ажиллагааг зөвхөн сахилгын зөрчил гаргасан, эсхүл ажил эрхлэх чадваргүй болсны үндсэн дээр ихэнх төлөв буюу бүхэлдээ шүүгч нараас бүрдсэн сахилгын баг хэрэгжүүлэх учиртай. Эдүгээ шүүгч нарыг ажилд томилох, дэвшүүлэх, сахилгын шийтгэл ногдуулах, бүрэн эрхийн хугацаа, цалин хангамж ба шүүхийн санхүүжилттэй холбоотой хараат бус байдлын үндсэн баталгаа Монгол Улсад үндсэн хуулийн болон бусад хуулийн түвшинд бий болсон гэж үзэж болно. Тэгвэл шүүгчийн хараат бус байдлыг зөвхөн шүүхийн албан тасалгаанд бус амьдралынх нь бүх орчинд авч үзэх ёстой. Албан ажил мэргэжлийн хараат бус байдал, хувийн хараат бус байдал гэх зэрэг шүүгчийн хараат бус байх бүхий л бололцооны түвшинд судлах нь чухал. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх онцгой чиг үүрэг бүхий шүүгч нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээн тогтоох баталгаа болдог тул ардчилсан нийгмийн аль ч үед анхаарлын төвд байдаг. Тийм ч учраас шүүгчид хууль зүйн мэдлэг, ур чадвар, туршлага төдийгүй ёс зүй, зан чанарын хувьд бусдаас хүлээн зөвшөөрөгдсөн байж, аливаа нөлөөллөөс ангид, хэнээс ч хараат бус байдлаар үйл ажиллагаа явуулж гагцхүү хууль, шударга ёсонд захирагдах учиртай гэжээ.

3.2. Шүүгчийн хараат бус байдлыг хангаж хамгаалсан тухай Тайваны туршлага

Энэхүү хэсгийг 2018 онд Тайваны Тайпэй хотод болсон Монгол Улсын шүүхийн шүүгч, ажилтнуудын сургалт, сургалтын материал, өөрийн гар тэмдэглэл зэргийг эх сурвалж болгон бичсэн болно.

Тайваны Үндсэн хуулийн 80 дугаар зүйлд “Шүүгч нам бүлгээс ангид байхаас гадна, хуулийн дагуу аливаа нөлөөнд автахгүй, бие даан шийдвэр гаргах ёстой”, 81 дүгээр зүйлд “Шүүгч нь хугацаагүй томилогдох ба эрүүгийн хэрэг болон ёс зүйн гэмт хэрэгт холбогдож албан тушаалаас огцруулсныг зарлахаас нааш албан тушаалыг авч болохгүй. Хуулийн

²⁸ Шүүхийн ерөнхий зөвлөл, Олон Улсын онол-практикийн бага хурлын илтгэлийн эмхтгэл-Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахад шүүхийн захиргааны үүрэг, тулгамдсан асуудлууд-2014, 22 дахь тал

үндэслэлгүйгээр албан үүргийг зогсоох, шилжүүлэх, цалин тэтгэмжийг бууруулж болохгүй” гэж хууль зүйн болон эдийн засгийн баталгааг тусгаж өгсөн байна.

Мөн 2012 оноос хэрэгжиж эхэлсэн Шүүгчийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Шүүгчийн хараат бус, бие даан шүүн шийдвэрлэх эрхийг хангах, шүүгчийг өөрийг нь хамгаалах, мөн шүүгчийг үнэлэх системийг бий болгох, ард иргэдийн шударга шүүлгэх эрхийг хангахад” оршино гэж хуулийн зорилгоо тодорхойлжээ.

Тайваньд 1949-1988 онд буюу тоталитар дэглэм тогтож байсан ба энэ хугацаанд шүүхийн хараат бус байдлыг үндсэн хуульд тодорхой заасан боловч шүүгчийг намын ноёрхлын хэрэгсэл болгож, шүүхийн үйл ажиллагаа зөвхөн намын дэглэмийг хамгаалах, засгийн газарт үйлчилдэг байжээ. Тухайн үед шүүгчийн хараат бус байдлын тухай ойлголт огтхон ч байгаагүй²⁹ гэжээ.

Шүүх олон нийтийн эрх ашгийг хамгаалах, хэрэг маргааныг таслах үүрэгтэй, хамгийн гол нь нийгмийн итгэлийг бүрдүүлэхэд оршдог гэж үздэг байсан боловч Гоминданы нам шүүх засаглалд хяналт тавьдаг, шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлдөг байсны улмаас олон нийтийн итгэх итгэл алдарсан байжээ.

Гэвч нийгэмд шүүхийн бие даасан байдалд улс төрийн эрх чөлөө, олон ургалч үзэл чухал үр нөлөөтэй, эс тэгвээс шүүх засаглал, цаашлаад улс орон оршин тогтнохгүй гэсэн үзэл санаа гарч ирсэн байна. Улмаар 1988 онд Гоминданы намын тоталитар дэглэм унаж нам байгуулах, хэвлэн нийтлэх, жагсаал цуглаан хийх боломж нээгдсэнээр шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал бүрдэх нөхцөл боломж аажмаар бүрдэж эхэлжээ.

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангаж хамгаалах орчин нөхцөл бүрдэхэд дараах үйл явдлууд онцгой нөлөө үзүүлсэн байна.

Нэг. Гао Шинь Ү прокурорын дуулиант хэрэг

Гао Шинь Ү прокурор Шинжүгийн орон нутгийн прокурорын газар ажиллаж байхдаа Шүүх юань³⁰-ий шүүхийн сахилгын асуудал хариуцсан дарга эхнэрээрээ өмгөөлөгч хийлгэн хэрэгт холбогдогчоос хахууль авч, улмаар хэрэг хариуцсан прокурорт шахалт үзүүлж, шүүхийн шийдвэрт нөлөөлдөг байсан явдлыг ил болгосноор ард түмний эсэргүүцэлтэй тулгарсан ба Гао прокурор дээрх хэргийг өөрийн харьяаллын бус гэдгийг үл харгалзан шалгасан нь нийгмийг цочоосон үйл явдал болжээ. Ерөнхий прокурор уг хэргийг авч өөр прокурорт шилжүүлэхийг тушаасан боловч Гао прокурор татгалзаж, үргэлжлүүлэн шалгасан нь нийгэмд хурцадмал байдал үүсгэсэн байна.

Гэвч уг хэргийг шүүхээс гэм буруугүй гэж үзсэн төдийгүй хэргийг шалгах явцад хахууль авсан дарга, ерөнхий шүүгчтэй удаа дараа нууцаар утсаар холбогдож байсан нь илэрсэн тул нийгэмд дахин бухимдал, эсэргүүцэл үүсгэсэн.

Мөн дээрх хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт Шүнжү бүсийн олон шүүгч, прокурор, мөрдөн байцаагч нар дургүйцлээ илэрхийлж ажлаасаа халагдах өргөдөл гарган, шүүхийн сахилга бат алдагдаж буйд нийгэм даяар анхаарлаа хандуулахыг уриалжээ.

Хоёр. Хууль зүйн сайдад холбогдох хэрэг

²⁹ 2018 оны Тайнваны Тайпей хотод зохион байгуулагдсан Монголын шүүгч, ажилтны сургалтын материал, 208 дахь тал. Жан Шэн Шин профессорын хичээлийн хэсгээс...

³⁰ Шүүх юань нь Тайваны шүүх эрх мэдлийн дээд байгууллага юм.

Таоюаны орон нутгийн прокурорын газрын прокурор Пэн Шао Жин гольфийн талбай хөрс сүйтгэж байгаа хэргийг шалгахад хууль зүйн сайд ажлаа авахаас өмнө хууль зөрчин эрх бүхий байгууллагыг лоббидож гольфийн талбай эзэмших зөвшөөрөл авч өгснийг илрүүлсэн байна. Гэвч хэргийг шалгах явцад Пэн дээд газрын дарамт шахалттай олонтой тулгарч, эцэст нь хэрэг хаагджээ. Харин Пэн үүнийг эсэргүүцэж ажлаасаа гарсан ба дараа нь сөрөг хүчний намаас нэр дэвшиж парламентад сонгогдож, дээрх хэргийг дахин сөхөх талаарх хөдөлгөөнийг өрнүүлжээ.

Гурав. Шүүгчийн хараат бус байдлын төлөөх хөдөлгөөн

Бүх шатны шүүх жил бүрийн эцэст шүүхийн дарга /ерөнхий шүүгч/ танхимын болон шүүгчдийн хурал хийж, хууль тогтоомжид заасны дагуу дараа оны ажил үүргийн хуваарь³¹ болон гүйцэтгэх дарааллаа тогтоодог байсан. Ямар хэргийг хэн гэдэг шүүгч шийдвэрлэх болон хэрэг хуваарилах аргачлалыг шүүх юаниас тогтоодог байсан ба Тайваны Шүүх байгууллагын хуулийн 79 дүгээр зүйлд “оны эхний хурлаар тухайн жилийн бүрэлдэхүүнтэй шүүх хурлын шүүгчийг урьдчилан томилно³²” гэж заажээ.

Ажил үүргийн хуваарилалт ба шүүхийн хараат бус байдал: 1993 оноос өмнө шүүхийн ажил үүргийг зөвхөн ерөнхий шүүгч бие даан хуваарилдаг байсан ба энэ талаар ямар ч хуулийн зохицуулалт байхгүй, шүүгч нарын хурал³³ огт хийддэггүй байсан.

Ажил хуваарилах эрх, шийдвэрлэх хэргийн төрөл, хүсэл сонирхол зэргийг зөвхөн ерөнхий шүүгч бие даан шийдвэрлэдэг байсны улмаас шүүгчид хэрэг шийдвэрлэх хувийн сонирхлоо хангах, тушаал дэвших боломжийг олж авахын тулд ерөнхий шүүгчид таалагдах гэж хэтэрхий хөөцөлдөх, энэ байдлыг ашиглан ерөнхий шүүгч шүүхийн шийдвэрт хөндлөнгөөс нөлөөлдөг байжээ.

Тайжун хотын орон нутгийн шүүхийн шүүгчдийн санаачилга: Тайжун хотын орон нутгийн шүүхийн хэсэг залуу шүүгч 1993 оны сүүлээр шүүгчийн хараат бус байдлыг хангах хөдөлгөөн өрнүүлж, улмаар гарын үсэг цуглуулан, шүүхийн ерөнхий шүүгчдээ шүүхийн бүтцийн тухай хуулийн дагуу ажил хуваарилах эрхийг нийт шүүгчдээр хэлэлцүүлж, ажил хуваарилах журмыг батлахыг шаардсан. Дээрх санаачилгыг хуучин тогтолцооны үеийн хуульчид байж болохгүй үзэгдэл гэж үзэж, хүлээж авахгүйн улмаас захиргааны эсэргүүцэлтэй тулгарч, шүүгчдийн хооронд үзэл бодлын зөрчилдөөн үүсжээ.

Улмаар газар бүрийн шүүгчид гарын үсгээ зурах дээр санал нэгдэж, тэмцэл өрнөсөн ба хэвлэл мэдээллийн хэрэгслээр “Шүүгчийн хараат бус байдал хөдөлгөөн” гэсэн нэвтрүүлэг цацагдаж, шүүхийн шинэчлэлийг шүүгчид өөрсдөө эхлүүлээ гэсэн эерэг мэдээлэл нийгэмд хүрэх болсон байна.

Тайжун хотын орон нутгийн шүүх шүүгчдийн хурлаараа “Ажил үүрэг хуваарилах журам”-ыг баталсан ба үүгээр ерөнхий шүүгчийн субъектив шийдвэрээр ажил хуваарилах явдал тус хотод эцэс болжээ.

Өнөөдрийн байдлаар бүх шатны шүүхийн шүүгчийн шийдэх хэргийн төрөл, тоог нийт шүүгчдийн хурлаар шийдвэрлэж байна. Урьд өмнө ерөнхий шүүгч өөрийн ивээлдээ багтсан шүүгч нарт авлигын том хэргүүдийг нэр зааж хуваарилдаг байсан учраас хэрэгт холбогдогч дарга нарын хэргийг хэрэгсэхгүй болгох, давж заалдсан тохиолдолд дээд шатны шүүгч нарт

³¹ Ажил үүргийн хуваарийг хэрэг хуваарилах гэдэг утгаар ойлгож болно.

³² Энэхүү эрх зөвхөн ерөнхий шүүгчид байсан.

³³ Манайхаар шүүгчдийн зөвлөгөөн юм.

нөлөөлөх байдлаар анхан шатны шийдвэрийг хэвээр үлдээх явдал хэвийн үзэгдэл байсан юм.

Шүүхийн төсөв ба үндсэн хууль: Шүүгчид ажил үүргийн хуваарилалтаа амжилттай шийдсэн боловч шүүхийн төсөв шүүгчийн хараат бус байдлыг хангах хэмжээнд байгаагүй юм. Шүүхийн тухайн жилийн төсвийн санал нь шат шатны захиргааны байгууллагууд дээр хасагдан, батлагдаж байгаа нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг алдагдуулах гэсэн оролдлого гэж үзсэн тул Тайжун хотын орон нутгийн шүүхийн шүүгч нар дахин нэгдэж, нийт шүүгч нарыг хамруулан үндсэн хуульд шүүхийн төсвийг бие даасан байх тухай заалт оруулах хүсэлт шаардлагыг парламентад хүргүүлсэн. Бүх шүүгч нар шаардлага хүргүүлснээр парламентад олонх болон сөрөг хүчний намын аль алиных нь дэмжлэгийг авч, үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Үндсэн хуулийн нэмэлт 5VI заалтад “Шүүх юаниас өргөн барьсан **оны төсвийг засгийн газар хасах эрхгүй**, зөвхөн саналаа нэмж оруулж болох ба төв засгийн газрын нэгдсэн төсвийн хамт парламентаар хэлэлцүүлнэ” гэж тусгасан.

Дөрөв. Тайнаны шүүхийн даргын нөлөөлөх оролдлого

Тус орон нутгийн шүүхийн дарга урьдчилан ялын тогтоолыг уншиж танилцаад оногдуулсан ял нь хэрэгт тохирохгүй гэсэн шалтгаанаар тухайн хэргийг хариуцсан шүүгчийг өрөөндөө дуудаж, гаргасан шийдвэрт хүчээр нөлөөлөхийг оролдсон байна. Хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгч шүүхийн даргыг энэ хэрэгт оролцож магадгүй гэж урьдчилан таамагласан учраас биедээ дуу хураагч авч өрөөнд нь орсон ба ялын тогтоолыг өөрчлөхийг шаардсан бүхий л яриаг бичиж авчээ. Дараа нь бичлэгийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр цацагдсанаар Тайнаны шүүхийн дарга ажлаасаа огцорсон байна.

Тав. Ялын тогтоолыг хянадаг системийг халсан нь

1995 онд Тайжун хотын орон нутгийн шүүхийн шүүгчид ялын тогтоолыг хянуулахаар хүргүүлдэг системийг эсэргүүцэж “Хайрцгийг чамд, хараат бус байдлыг надад” нэртэй хөдөлгөөнийг өрнүүлж, шүүхийн шийдвэр хараат бусаар гарах нөхцөлийг бүрдүүлэхийг шаардсан байна.

Олон арван жилийн турш Тайваны шүүх шийдвэрээ эцэслэж /яллах дүгнэлтээ үйлдэх/ гаргахаас өмнө шүүхийн шийдвэрийг хяналтын хайрцагт хийж шүүхийн даргад хүргүүлэн хянуулдаг “хүргүүлэн танилцуулах систем” үйлчилдэг байсан ба зөвхөн шүүхийн дарга танилцаж дууссаны дараа сая ялын тогтоолыг төлөвлөдөг байжээ.

Дээрх системийг олон нийт шүүхийн шийдвэрт хөндлөнгөөс нөлөөлөх нэг хэлбэр гэж шүүмжилж байсан юм.

“Хүргүүлэн танилцуулах систем” анх хэрэгжиж эхлэхдээ гол зорилго нь ажлын туршлагатай танхимын тэргүүн, шүүхийн дарга нар яллах дүгнэлттэй танилцах нь шийдвэрийн үнэн зөв байдлыг хангана гэж үзсэн ба хэрвээ яллах дүгнэлт буруу, алдаатай байвал туршлагатай шүүгч, дарга нар засаж залруулах нь олон нийтийн итгэлийг хүлээн гэж үзсэн байна. Хэдий ийм боловч үнэн хэрэгтээ шүүхийн шийдвэрт хөндлөнгөөс нөлөөлдөг гэх гомдол санал их гарч, дээрх системийг шүүхийн дарга сөргөөр ашиглан хууль бус нөлөөлөл хийж байна гэж үзэх болсон.

Зургаа. Шүүхийн шинэчлэлийн амжилтын үндэс

Улс төрд сөрөг хүчний намын бодлогын дэмжлэг нэмэгдэж, нийгэмд олон ургалч үзэл газар авч, Гоминданы намын нийгмийг хянах хяналт суларсан нь шүүхийн шинэчлэл бүрэлдэн бий болоход дэмжлэг болохоос гадна хэвлэлийн эрх чөлөөт орчин, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд шүүхийн шинэчлэл хийх тэмцлийг эергээр хүлээн авч, шүүхийн талаарх нийгмийн хандлагыг өөрчилж байсан нь чухал нөлөө үзүүлсэн байна.

Улмаар улс төрийн нам хоорондын өрсөлдөөний улмаас эрх баригч эсэхээс үл хамааран шүүхийн үйл ажиллагаанд зохих хүрээ хэмжээгээ мэдэрч, шийдвэрт нөлөөлөхөөс зайлсхийх болжээ.

Долоо. Дээд шүүхийн шүүгч ажлаасаа халагдав

Дээд шүүхийн шүүгч өөрийн хүүг зам тээврийн осол гаргах үеэр урьд нь гэмт хэрэгт холбогдож байсан түүхийг устгах гэж тухайн хэргийг хариуцсан шүүгчтэй олон удаа утсаар ярьж, мөн өөрийн биеэр очиж уулзан ятгаж байжээ.

Анхан шатны шүүхээс гэм буруутай хэмээн ялласны дараа тухайн шүүгч давж заалдах шатны шүүхийн танхимын тэргүүнд нөлөөлөхийг оролдсон ба энэхүү явдал шүүгчдийн форумын дотоод сүлжээнд дэлгэгдсэнээр нийгэмд шуугиан тарьсан байна.

Энэхүү хэрэг нийгэмд ил болсны дараа дээд шүүхийн дотоод шалгалтын дүгнэлтээр тухайн шүүгчийг зөвхөн хамт ажилладаг шүүгч нараасаа туслах, санаа тавихыг сануулсан /гуйсан/ болохоос дарамт шахалт үзүүлээгүй гэж үзжээ.

Шалгалтын дүгнэлтэд анхан шатны шүүхийн шүүгчид дургүйцэж, болсон явдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил болгож, шүүгчийн хууль бус үйлдлийг шүүх хамгаалж байна гэдгийг олон нийтэд мэдээлсэн. Иймд Шүүх юань дээд шүүхийн шалгалтын дүгнэлтийг хүчингүй болгож, шүүгчид сахилгын шийтгэл оноосон ба тухайн шүүгч аргагүйн эрхэнд тэтгэвэртээ гарч, ажлаа өгчээ.

Найм. Нууцаар хэрэг хуваарилах системийг халсан нь

Тайваны шүүхийн тухай хуульд зааснаар Дээд шүүх нь хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэх хамгийн дээд шатны эрх мэдэл бүхий байгуулга юм.

Гадаад орчноос шүүгчид нөлөөлөх, ятгалга, авлига зэргээс сэргийлж Дээд шүүх 1950 оноос эхэлж хэрэг хуваарилах нууц системийг хэрэгжүүлж ирсэн ба шүүхийн шийдвэр гарахаас өмнө болон хойно шүүхийн гаднах орчинд хэрэг хариуцсан шүүгчийн талаарх мэдээлэл байдаггүй байсан.

Гэвч энэхүү системийг олон нийт шүүгчийн хариуцлагаас мултрах луйвар мэтээр хардах болсноор 2012 оны эхээр Дээд шүүхийн дарга, мөн Тайпэй хотын орон нутгийн шүүхийн шүүгч Лин зэрэг шүүгчид 500 гаруй анхан шатны шүүхийн шүүгчийг нэгтгэж, “Дээд шүүхийн шинэчлэлт, үлэг гүрвэлийн үеийн шүүх системийг халъя” гэсэн хөдөлгөөнийг өрнүүлж, нууцаар хэрэг хуваарилах системийг халахыг шаардсан. Үүнийг тухайн үеийн Тайваны ерөнхийлөгч Ма болон Шүүхийн ерөнхий газрын дарга Лай нар дэмжиж байгаагаа илэрхийлсэн байна.

Иймд Шүүх юаниас “Дээд шүүхийн ажил үүргийн журам”-д өөрчлөлт оруулж, хэрэг хуваарилалт нууц байна гэсэн заалтыг хасжээ. Улмаар Дээд шүүхийн 2012.04.09-ны өдрийн хуралдаанаар уг системийг бүхэлд нь халсан байна. Ийнхүү 62 жил хэрэгжсэн хэрэг хуваарилах нууц систем албан ёсоор халагдаж түүх болон үлджээ.

Ес. Шүүхийг ятгах болон нууцаар чагнасан хэрэг

2013 оны 9 дүгээр сард Улсын ерөнхий прокурорын газраас хэвлэлийн бага хурал зарлаж, улсын ерөнхий прокурор Хуан чагнах төхөөрөмжийн бичлэгт үндэслэн Хууль зүйн сайд (прокурорын шууд харьяалах дээд албан тушаал) Зэн, Дээд шүүхийн прокурорын газрын дарга Чэн болон парламентын дарга Ван зэрэг хүмүүс, сөрөг намаас сонгогдсон гишүүн Хэ-д холбогдох эрүүгийн хэргийн төлөө бусдыг ятган, шүүх ажиллагаанд саад учруулахыг оролдсон болохыг тогтоосон тухай мэдээлсэн. Гэвч мөрдөн байцаалтын явцад холбогдох хүмүүс авлига авсан нь тогтоогдоогүй, гэм буруугүй гэж шүүхээс үзсэн тул дахин хэвлэлийн хурал зохион байгуулж, мэдээлэл болон баримтыг ил болгожээ.

Дээрх үйл явдалтай холбогдуулан хэрэг хариуцсан прокурор ёс зүйн хороогоор бусдын үгэнд автсан нь батлагдсан ч гэм буруугүй гэсэн шийдвэр гаргасан учраас тус шийдвэрт давж заалдах гомдол гаргаж, гэм буруутайд тооцуулсан бол Хууль зүйн сайд Зэн, улсын ерөнхий прокурор Чэн нар бусдын ятгалгад орсон гэх үндэслэлээр огцорсон байна. Харин парламентын даргыг Ерөнхийлөгч Ма шүүх ажиллагаанд саад учруулсан нь баримтаар нотлогдсон тул намын сахилга зөрчсөн гэдэг үндэслэлээр намаасаа хөөсөн байна.

Тайваньд дээрх явдлаас хойш төрийн удирдлагад аль нам гарахаас үл хамаарч шүүхэд нөлөөлдөг явдал давтагдахаа больсон гэж үздэг байна.

Арав.Шүүхийн шийдвэр дэх олон нийтийн хяналт

Тайваньд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг бий болгохын төлөөх хэдэн арван жилийн олон үйл явдлын үр дүнд шүүгч бие даан, хараат бусаар шийдвэр гаргах нөхцөл боломж бүрдсэн байна.

Олны анхаарал татсан хэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон интернэтийн орчинд цацагдсанаар тухайн хэргийг шүүх хянан шийдвэрлэхэд асар их нөлөөтэй гэж үздэг.

Шүүгч телевизийн төрөл бүрийн нэвтрүүлэг, мэдээ, интернэт дэх саналуудад хэрхэн төвийг сахисан байр сууриа хадгалж, хуулийн дагуу хянан шийдвэрлэх нь хамгаас чухал байна.

НЭГ. НӨЛӨӨЛЛИЙН МЭДҮҮЛГИЙН ХӨТЛӨГДСӨН БАЙДАЛ

2013-2019 онд нийт хөтлөгдсөн 41 мэдүүлгийн 36-д хууль тогтоомжид заасан холбогдох ажиллагаа хийгдсэн байна. Үүнээс 19 мэдүүлгийг ШЕЗ хүлээн авч, хянаад 1-ээс³⁴ бусдыг нь ШТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасныг зөрчсөн, шүүгчид нөлөөлөхийг оролдсон гэх ерөнхий үндэслэл, агуулгаар ШЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5-т, 38 дугаар зүйлд заасны дагуу холбогдох байгууллагад шилжүүлжээ. Харин 17 мэдүүлгийг хянаад "...цугласан баримтаас үзэхэд хариуцагчийн гаргасан үйлдэл ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй" гэдгээр хариу хүргүүлж, шийдвэрлэсэн байна.

Тодруулбал, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс цагдаагийн байгууллагад шилжүүлсэн 18 мэдүүлгийн 8-ийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргаж, харьяа прокурорын газарт хүргүүлсэн ба прокуророос "... гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлгүй тул ЭБШХ-ийн 175 дугаар зүйлийг үндэслэн, мөн ...шүүгчийг тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэх явцад нөлөөлөх оролдлого хийгээгүй, нөлөөлөх оролдлого хийсэн нь тогтоогдоогүй, эрүүгийн эрх зүйн шинжийг агуулаагүй" зэрэг үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэжээ.

Харин ШЕЗ-өөс анхан шатны шүүхэд 10 мэдүүлгийг "...холбогдох этгээдийн үйлдэл ШТХ-ийн 27.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн нь шүүгчид нөлөөлөх оролдлого үзүүлсэн гэж үзэх үндэслэлтэй" тул ШЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5, 38 дугаар зүйлд заасны дагуу шилжүүлснээс 9 мэдүүлгийг "шүүгчид шууд болон шууд бус нөлөөлөхийг оролдсон болох нь нотлох баримтаар тогтоогдсон, ШТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй" гэж үзэн торгох шийтгэл ногдуулж шийдвэрлэсэн. 1 мэдүүлгийг "...мэдүүлэгт холбогдох этгээдийн үйлдэл нь нөлөөлөх оролдлогын шинжтэй боловч тухайн этгээдэд нөлөөлөх оролдлого гаргасан тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэх талаар танилцуулж, гарын үсэг зуруулж, баталгаажуулаагүй байх тул өмгөөлөгчийг шүүгчийн хараат бус байдалд нөлөөлсөн гэж үзэж, хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэлгүй" гэж дүгнээд ШЕЗ-ийн гаргасан хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Шүүх нөлөөллийн мэдүүлэгт холбогдох хэргийг хянан шийдвэрлэхдээ нөлөөллийн арга, хэлбэрийг нарийвчлан дурдаж, ойлголтын хүрээллийг тодорхойлж, яг ямар хэлбэрээр, яаж нөлөөлөхийг оролдсон талаар огт дурдаагүй нь учир дутагдалтай байна.

Эндээс дүгнэж үзэхэд Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчид нөлөөлөх оролдлого үзүүлсэн этгээдийн үйлдлийг гэмт хэргийн шинжтэй эсэх, холбогдох хууль тогтоомжид заасан ямар хариуцлага хүлээлгэх асуудлыг хуралдаанаар авч үзэхгүйгээр зөвхөн эрх бүхий албан тушаалтны тоот бичгээр эрх бүхий байгууллагад ШТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасныг зөрчсөн гэсэн ерөнхий үндэслэлээр шилжүүлсэн нь тухайн байгууллага /Цагдаа, Прокурор/-аас эрүүгийн эрх зүйн шинжийг агуулаагүй, нөлөөлсөн гэх үйлдэл гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, тогтоогдохгүй гэх байдлаар эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх үндэслэл болсон гэж үзэхээр байна.

Өөрөөр хэлбэл ШЕЗ ШЭЗБТХ-ийн 22.5-д "Шүүхийн ерөнхий зөвлөл ...тухайн этгээдийн үйлдэл нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан гэж үзвэл түүнийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад хандаж, шийдвэрлүүлнэ.", "Нөлөөллийн мэдүүлгийг шийдвэрлэх журам"-ын 3.5-т "Шүүгчийн хараат бус байдалд

³⁴ 2014 онд нэг мэдүүлгийг "шүүгчийн хараат бус байдалд халдсан үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй гэж үзэн" Эрүүгийн хуулийн 110, 111, 259 дүгээр зүйлд заасан үндэслэлээр цагдаад шилжүүлсэн.

халдсан үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй гэж Ерөнхий зөвлөл үзвэл Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5-д заасны дагуу нөлөөллийн мэдүүлэгт тэмдэглэн баталгаажуулсан этгээдийг шалгуулахаар нөлөөллийн мэдүүлэг, түүнд холбогдох баримт бичгийг Цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх газарт шилжүүлнэ”, 3.6-т “Шүүгчийн хараат бус байдалд халдсан үйлдэлд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэхээр байвал нөлөөллийн мэдүүлэг хариуцсан ажилтан Ерөнхий зөвлөлийн хүсэлт, нөлөөллийн мэдүүлэг, түүнд холбогдох баримт бичгийг харьяалах шүүхэд хүргүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2013-2019 онд зөвхөн 1 мэдүүлгийг л ШЕЗ-ийн хуралдаанаар хэлэлцэж, холбогдох байгууллагад хандаж, шийдвэрлүүлсэн юм.

Шүүхийн захиргааны тухай хуулийн 15 дугаар зүйлд ШЕЗ-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хуралдаан бөгөөд эрх хэмжээний асуудлыг хуралдаанаар хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэхээр заасан. Гэвч хууль тогтоомжид заасны дагуу аливаа этгээдийн бүх үйлдэлд³⁵ хамааруулан хөтөлсөн шүүгчийн нөлөөллийн мэдүүлгийг ШЕЗ хянахгүйгээр, зөвхөн эрх бүхий албан тушаалтны хүрээнд авч үзсэн нь нэг хүний үзэмж, хандлагаар асуудалд хандсан, ажиллагаа хийгдсэн гэсэн эргэлзээг төрүүлж байна.

Нөлөөллийн арга, хэлбэр, үйлдэл нь адилхан хэд хэдэн мэдүүлгийг нэг үндэслэлээр 2 өөр байгууллагад шилжүүлсэн, өөрөөр шийдвэрлэсэн тохиолдол байгаа юм. Хөтлөгдөн ирсэн мэдүүлэгт хийх ажиллагаа удааширсан, дутуу хийгдсэнтэй холбоотойгоор 2 мэдүүлэгт холбогдох байгууллагаас эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, ШЕЗ-ийн хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Мөн ШЕЗ-өөс шүүгчид нөлөөлөх гэж оролдсон этгээдийн үйлдлийн эрх зүйн шинжийг зөв тодорхойлоогүй, хянан шийдвэрлэх харьяаллын бус байгууллагад шилжүүлсэн зэрэг процессын алдаа гарсан байна. Энэ нь хууль тогтоомжид³⁶ өөрчлөлт орсон, мөн нөлөөллийн мэдүүлэг хариуцсан ажилтны тогтвор суурьшилгүй байдал³⁷, журмын хэрэгжилтэд мониторинг хийгээгүй, өөрчлөлт оруулаагүй зэрэг нөхцөл байдлаас шалтгаалсан байхыг үгүйсгэхгүй.

ХОЁР. ШҮҮГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Анхан болон давж заалдах шатны 27 шүүхийн 132 шүүгчийг хамруулан судалгааг гүйцэтгэсэн.

Судалгааны эхний хэсэгт шүүгчдийн нөлөөллийн мэдүүлгийн талаарх ойлголт, нөлөөлөх оролдлого үзүүлж байсан тохиолдол, нөлөөлөх оролдлого үзүүлсэн этгээд, нөлөөлөх оролдлогод мэдүүлэг хөтлөөгүй шалтгаан зэргийг тодорхойлох, хоёрдугаар хэсэгт Монгол Улсад шүүгчийн хараат бус байдал хэрхэн хангагдсан талаарх шүүгчдийн үнэлгээ, хараат бус байдлыг хангахад нөлөөлөх хүчин зүйл, нөлөөллийн мэдүүлэг хөтлөх хэлбэр үр дүнтэй эсэх, хараат бус байдал шүүгчээс өөрөөс хамааралтай эсэх, мөн шүүхийн дотоод хараат бус байдал хангагдсан байдал, цаашид “Нөлөөллийн мэдүүлэг шийдвэрлэх

³⁵ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “нөлөөллийн мэдүүлэг гэж хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн хэрэг, маргааны шийдвэрлэлттэй холбогдуулан шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээдээс нөлөөлөх гэж оролдсон бүх үйлдлийг тэмдэглэн баталгаажуулсан, эрүү, иргэн, захиргааны хэргийн материалд хавсаргагдах баримт бичгийг” ойлгохоор заажээ.

³⁶ 2016, 2017 онд Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиуд шинэчлэгдэн батлагдсан, Зөрчлийн тухай хууль шинээр батлагдаж, дагаж мөрдөгдсөн.

³⁷ 2013-2019 онд тухайн албан тушаалд 8 ажилтан солигдсон.

журам"-ын хэрэгжилтийг сайжруулахад авах арга хэмжээний талаарх саналыг шүүгчдээс авсан.

Судалгаанд хамрагдсан шүүгчдийн 82 хувь нөлөөллийн мэдүүлэг хөтлөх талаарх ойлголт сайн, 17 хувь нь дунд зэрэг, 1 хувь муу гэж хариулсан. Гэхдээ шүүгчид нөлөөлөх оролдлого үзүүлсэн тохиолдол бүрд нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй шалтгаан, "Нөлөөллийн мэдүүлэг шийдвэрлэх журам"-ын хэрэгжилтийг сайжруулахад нөлөөлөх хүчин зүйлд шүүгчдийн 48 хувь нь шүүгчдэд нөлөөллийн мэдүүлгийн талаарх сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах гэж хариулсан зэргээс үзэхэд шүүгчдэд нөлөөллийн мэдүүлэг хөтлөх талаарх ойлголтыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагатай нь харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан 132 шүүгчийн 30 буюу 23 хувь нь өмнө нөлөөллийн мэдүүлэг хөтөлж байсан, 77 хувь нь хөтөлж байгаагүй гэсэн юм. Харин шүүгчдийн 57 буюу 43 хувь нь хэн нэгэн этгээдээс нөлөөх оролдлого үзүүлж байсан гэж хариулсан.

Эдгээр шүүгчдээс нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй шалтгааныг хэд хэдэн сонголттой хариултын хувилбараар тодруулахад шүүгчдийн 17 нь нөлөөллийн мэдүүлэг хөтөлснөөр ирж болох дарамт шахалтаас эмээдэг, 42 нь ажлын ачаалал их, журамд заасан ажиллагааг хийхэд төвөгтэй /тайлбар гаргах, мэдүүлэг өгөх/, 16 нь нөлөөллийн мэдүүлгийн хэлбэрт бүх талын нөлөөлөл тусгагдаагүй, 5 нь танил тал татдаг, 1 шүүгч мэдүүлэг хөтлөх талаарх ойлголт муу гэсэн бол 3 шүүгч шалтгаан байхгүй гэж хариулсан байна. Харин нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй өөр шалтгааныг асуулгын бусад хэсэгт, мэдүүлэг хөтлөх хэмжээний нөлөөлөл биш гэж үздэг, тухайн хэргийн оролцогчийн эрх юм, оролдлого үзүүлсэн этгээдэд нөлөөллийн мэдүүлгийн талаар сануулахад дахин ийм асуудал гаргахгүй гэсэн, тухайн байгууллагын удирдлагад мэдэгдсэн, тухайн үеийн хуульд байгаагүй, нөлөөлөл гэж бодоогүй, шаардлагагүй гэж үзсэн, байнга л сахилгын хороо, АТГ-д өгнө гэдэг шүү дээ, өөрт нь хэлснээр үйлдлээ шууд зогсоосон гэсэн юм.

Эндээс дүгнэж үзэхэд шүүгчдийн нөлөөллийн мэдүүлэг хөтлөх талаарх ойлголт төдийлөн сайн биш, мөн нөлөөллийн мэдүүлгийн нууцлалыг хангах, журамд нөлөөллийн мэдүүлэгт хийх процессын ажиллагааг тодорхой заах, шүүгчдэд чирэгдэл учруулахгүйгээр шийдвэрлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх, мэдүүлгийн хэлбэрт бүх талын нөлөөллийн хэлбэрийг тусгах шаардлагатай байна.

Харин нөлөөлөх оролдлого үзүүлсэн этгээдийг хэд хэдэн сонголттой хариултын хувилбараар асуухад шүүгчдийн 33 нь хэргийн оролцогч, 32 нь улс төрийн албан тушаалтан (16), өмгөөлөгч (16), томилох эрх бүхий албан тушаалтан 4, дээд шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч 12, Шүүхийн ерөнхий зөвлөл 4 гэж хариулсан юм. Мөн хамгийн их нөлөөлж байгаа этгээд гэж эрх бүхий албан тушаалтны нэрийг бичсэнийг энд дурдах нь зүйтэй.

2017 онд Шүүхийн хараат бус байдлыг хамгаалах хэлтсээс хийсэн судалгааны "шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх боломжтой этгээд" гэсэн асуултад дээд шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч 10, тухайн шатны шүүгч, Ерөнхий шүүгч 7, ШЕЗ-ийн дарга, гишүүд 2, шүүхийн тамгын газрын дарга 2, шүүхийн захиргааны ажилтан 3 гэж хариулсан ба хоёр судалгааны үр дүнгээр шүүх доторх нөлөөлөл байдаг, харин дотоод нөлөөлөлд холбогдуулж мэдүүлэг хөтөлдөггүй гэдэг нь баталгаажиж байна.

2013-2019 онд улс төрийн албан тушаалтан буюу УИХ-ын гишүүнд холбогдуулж зөвхөн 1 удаа л шүүгч нөлөөллийн мэдүүлэг ШЕЗ-д хөтөлж ирүүлсэн. Харин энэхүү судалгааны үр дүнгээс харахад дээрх хугацаанд нөлөөлөх оролдлого үзүүлсэн улс төрийн албан тушаалтны 15, томилох эрх бүхий албан тушаалтны 4, дээд шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн 12, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 4 буюу нийт 35 удаагийн нөлөөллийн үйлдэлд мэдүүлэг огт хөтлөөгүй байна. Өөрөөр хэлбэл өнгөрсөн хугацаанд улс төрд нөлөө бүхий этгээдийн дарамт шахалт үзүүлэх болон бусад хэлбэрээр нөлөөлөх гэсэн аливаа үйлдэлд шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй гэсэн үг юм. Энэ нь далд утгаараа шүүгч мэдүүлэг хөтлөөгүй нь нөлөөлөлд автсан гэх агуулгыг илэрхийлж байна.

Шүүгчид нөлөөлөх оролдлого үзүүлсэн хэлбэрийн хувьд, хээл хахууль, шан харамж, бэлэг сэлт өгөхийг завдах 3, дарамт шахалт үзүүлэх 18, дарамтлах, заналхийлэх 14, доромжлох, гүтгэх 25, шүүгчийн бие, орон байр, унааны аюулгүй байдалд халдах 7, шийдвэрийг урьдчилан хэлэлцэхийг санал болгох 2, шийдвэрийн талаар урьдчилан зааварчилгаа өгөх 12, нөхцөл байдлыг тайлбарлах 26, бусад хэрэг, маргааны шийдвэрийг жишиг болгохыг санал болгох 16 тохиолдол тус тус байна. Бусад хэлбэр гэсэн сонголт дээр шүүгчид “шийдвэрлэгдээгүй хэрэг дээр болон үндэслэлгүйгээр Ёс зүйн хороонд гомдол гаргаж хандаж байсан, албан тушаалаа ашиглан нөлөөлөхийг оролдох, үндэслэлгүйгээр татгалзах, үг хэл амаар доромжлох” нийтлэг гэж үзсэн.

Эндээс дүгнэхэд хэргийн оролцогч төдийгүй шүүхээр үйлчлүүлж байгаа иргэдэд нөлөөллийн мэдүүлгийн талаарх хууль тогтоомжийг сурталчлан таниулах, эрх үүргийг сануулах, үг, үйлдэл бүр нөлөөлөх оролдлого болох эрсдэлтэй гэдгийг тогтмол сануулах, мөн шүүгчид нөлөөллийн хэлбэрийг нэг мөр ойлгох хэрэгцээ шаардлага байна.

Монгол Улсад шүүгчийн хараат бус байдал хангагдсан эсэхийг шүүгчдээс асуухад судалгаанд хамрагдсан нийт 132 шүүгчийн 79 буюу 60 хувь нь дунд зэрэг, 43 буюу 33 хувь нь муу, хангагдаагүй гэж үзсэн бол 10 буюу 7.5 хувь нь л “сайн” гэж хариулсан. Харин хараат бус байдлыг хангахад нөлөөлөх хүчин зүйлийн талаар шүүгчдийн 85.5 хувь нь эдийн засаг, хууль зүйн баталгаа, 68.5 хувь нь томилгооны хараат бус байдал, шүүгчийн өөрийнх нь ёс зүй, мэдлэг мэргэшил, ур чадвар гэж үзсэн юм. Шүүгчийн хараат бус байдлыг хангахад шүүгчээс өөрөөс хамааралтай гэдэгтэй шүүгчийн 96 хувь нь санал нийлдэг гэж үзсэн нь шүүгчийн хараат бус байдлыг хангаж хамгаалахад шүүгчийн өөрийн оролцоо чухал нөлөөтэй гэдгийг шүүгчид баталж байна. Гэхдээ зөвхөн шүүгчид өөрт нь хараат бус байдлыг нь даатгаад орхиж болохгүй, төр засгийн бодлогын хүрээнд шүүгчийн хараат бус байдлыг хангаж, хамгаалах асуудлыг тодорхойлж, эдийн засаг, хууль зүйн болон бусад батлааг хангах, нэмэгдүүлэх шаардлагатай.

Цаашид “Нөлөөллийн мэдүүлэг шийдвэрлэх журам”-ын хэрэгжилтийг сайжруулахад нөлөөлөх хүчин зүйлсийн талаар³⁸ шүүгчдийн 63 нь нөлөөллийн мэдүүлгийн талаарх сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах, 83 нь журмыг шинэчлэх /процессын ажиллагааг тодорхой заах, нөлөөлөх хэлбэрийн талаар албан ёсны тайлбар гаргуулах/, 79 нь хөтөлсөн мэдүүлгийн нууцлалыг нууцын журмаар хангах, 51 нь нөлөөлсөн тухай мэдээллийг хуульд заасан хугацаанд олон нийтэд мэдээлэх, 50 нь журмын хэрэгжилтийг сайжруулах чиглэлд захиргааны хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх, 46 нь төрийн байгууллагуудын хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах хүрээнд тодорхой арга хэмжээ авах, бусад чиглэлд иргэдэд сурталчлах, хөтөлсөн мэдүүлэг ШЕЗ холбогдох арга хэмжээ авдаггүй нь мэдүүлгийг хүлээн авч хянаж байгаа албан тушаалтны үзэмжээр шийдвэрлэгддэг гэж ойлгосон тул заавал шалгаж байх ёстой, хурдан хугацаанд шийдвэрлэгддэг болох,

³⁸ Хэд хэдэн сонголттой хувилбараар хариулсан.

нөлөөллийн мэдүүлэг тийм ч үр дүнтэй биш шүүгчийн өөрийнх нь мэдлэг ур чадвар, ёс зүй л чухал гэж үзсэн байна. Энэ нь нөлөөллийн мэдүүлгийг Шүүхийн ерөнхий зөвлөл хянахгүй, зөвхөн эрх бүхий албан тушаалтны хүрээнд хянагдаж байгаа, мөн хийгдэж буй холбогдох ажиллагаа удаашралтай, процессын төвөгтэй байдал нь шүүгчдийн мэдүүлэг хөтлөхгүй байх шалтгаан нөхцөл байж болохыг үгүйсгэх аргагүй юм.

Энэ бүхнээс дүгнэхэд Монгол Улсад шүүгч хараат бус, нөлөөллөөс ангид байх эрх зүйн орчин олон улсын нийтлэг зарчимд нийцэж Үндсэн хуулийн хүрээнд бий болсон, шүүгчид нөлөөлөх оролдлого үзүүлсэн этгээдэд мэдүүлэг хөтөлж, хариуцлага хүлээлгэх тогтолцоо бүрдсэн хэдий ч шүүгчийн хараат бус байдлын баталгааг бодит байдал дээр хангах асуудал учир дутагдалтай байна. Шүүгчийн хараат бус байдал хэр зэрэг хангагдсан талаар судалгаанд оролцсон шүүгчдийн зөвхөн 10 буюу 7.5 хувь нь л “сайн”, 13 хувь нь нөлөөллийн мэдүүлэг хөтөлснөөр ирж болох дарамт шахалтаас эмээдэг, өнгөрсөн хугацаанд улс төрд нөлөө бүхий этгээдийн дарамт шахалт үзүүлэх болон бусад хэлбэрээр нөлөөлөх гэсэн аливаа үйлдэлд шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй нь шүүгч хараат бус, нөлөөллөөс ангид байх тогтолцоог улам боловсронгуй, үр нөлөөтэй болгох хэрэгцээ шаардлага байгааг илэрхийлж байна.

Монгол Улсад шүүгч болох иргэнд тавигдах шаардлагад “...бусдын нөлөөнд автахгүй, бие даасан шийдвэр гаргах чадвартай”³⁹ байх гэсэн шалгуурыг хуулиар тавьсан хэдий ч үүнийг үнэлэх асуудал тодорхой аргачлал, шалгуур үзүүлэлтгүй байгаа нь учир дутагдалтай. Судалгаанд хамрагдсан шүүгчийн 96 хувь нь шүүгч хараат бус, нөлөөллөөс ангид байх нь шүүгчээс өөрөөс нь хамааралтай гэдэгтэй санал нийлдэг гэсэн юм.



³⁹ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д заасан.

ГУРАВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

1. Цаашид нөлөөллийн мэдүүлгийг заавал ШЕЗ-ийн хуралдаанд танилцуулж, шийдвэр гаргуулах асуудлыг журамлах. Нөлөөллийн мэдүүлгийг шийдвэрлэх журмын 3.4-д “Ерөнхий зөвлөлийн дарга нөлөөллийн мэдүүлэг болон түүнд холбогдох баримттай танилцаж, **шаардлагатай гэж үзвэл** Ерөнхий зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлнэ” гэснийг өөрчлөх;
2. Шүүгчдэд нөлөөллийн мэдүүлгийн талаарх сургалтыг жил бүр зохион байгуулах;
3. Нөлөөллийн журам, маягыг шинэчлэх /процессын ажиллагааг тодорхой заах, нөлөөлөх хэлбэрийн талаар албан ёсны тайлбар гаргуулах, нэг мөр ойлголтыг бий болгох/;
4. Шүүгчийн хөтөлсөн нөлөөллийн мэдүүлгийн нууцлалыг нууцын журмаар хангах, шүүгч мэдүүлгийг шүүхийн тамгын газраас дамжуулахгүйгээр шууд ШЕЗ-д хүргүүлдэг тогтолцоог бүрдүүлэх;
5. Шүүхийн ерөнхий зөвлөл нөлөөллийн мэдүүлгийг хянах, холбогдох ажиллагаа хийх хугацааг тодорхой заах;
6. Нөлөөллийн мэдүүлгийг холбогдох байгууллагад шилжүүлэхдээ хууль зүйн үндэслэл, нөлөөллийн үйлдийн эрх зүйн шинжийг дэлгэрэнгүй, зөв тодорхойлох;
7. Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, шийдвэрлэх асуудлаар холбогдох хуулийн байгууллагуудтай хэлэлцүүлэг хийх, нэгдсэн ойлголтод хүрэх, байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах чиглэлд тодорхой арга хэмжээ авах;
8. Шүүгчдийн эдийн засгийн баталгааг нэмэгдүүлэх чиглэлд тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
9. Шүүгч болох иргэнд тавигдах “...бусдын нөлөөнд автахгүй, бие даасан шийдвэр гаргах чадвартай” байх шаардлагыг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалыг батлах, томилгооны хараат бус байдлыг хангахад анхаарах;
10. Олон нийтэд нөлөөллийн мэдүүлгийг сурталчлан, таниулах;
11. Нөлөөллийн мэдүүлгийг хариуцсан ажилтан тогтвор суурьшилтай ажиллах баталгааг хангах, мэргэшүүлэх, тухайн ажилтны мэдүүлэгт хийх ажиллагаа, эрх, үүргийг тодорхой заах.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
2. Монгол Улсын Шүүхийн тухай хууль, 2012
3. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, 2012
4. Шүүхийн захиргааны тухай хууль, 2012
5. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, 2015
6. Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/, 2017
7. Захиргааны ерөнхий хууль, 2015
8. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/, 2016
9. Нөлөөллийн мэдүүлгийн маягт, 2013
10. Нөлөөллийн мэдүүлгийг шийдвэрлэх журам, 2015
11. ННФ, Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь: сэдэвт хэлэлцүүлэг, судалгааны эмхэтгэл, УБ., 2015
12. ШЕЗ, Шүүхийн хараат бус байдал. Олон улсын баримт бичиг, УБ., 2019
13. Шүүхийн ерөнхий зөвлөл, Олон Улсын онол-практикийн бага хурлын илтгэлийн эмхтгэл-Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахад шүүхийн захиргааны үүрэг, тулгамдсан асуудлууд, УБ., 2014
14. Н.Лүндэндорж, Шүүх эрх мэдэл, УБ., 2017
15. ШЕЗ, Шүүх эрх мэдэл сэтгүүл, УБ., 2014, №2, 2015, №4, 2017, №3, 4, 2018 №3
16. “Монголын төр эрх зүй” сэтгүүл, УБ., 1997, №2, “Шүүх, шүүгчдийн хараат бус байдлыг хангах асуудалд” өгүүлэл
17. 2018 оны Тайнваны Тайпей хотод зохион байгуулагдсан Монголын шүүгч, ажилтны сургалтын гарын авлага
18. Н.Лүндэндорж: Шүүгчийн хараат бус байдал нь хууль бус үйлдэл, хариуцлагаас нуугдах хана хэрэм биш, ярилцлага, 2019.03.18, өнөөдөр сонин.
19. [https://www.judiciary.uk/about-the-judiciary/the-judiciary-the-government-and-the-constitution/jud-acc ind/independence/](https://www.judiciary.uk/about-the-judiciary/the-judiciary-the-government-and-the-constitution/jud-acc-ind/independence/)
20. <http://www.conscourt.gov.mn/?p=4535>
21. <http://legaldata.mn/b/20>
22. <https://www.timothy-judge.com/Judge%20&%20Larsen.pdf>
23. <https://journalistsresource.org/studies/politics/elections/judges-elections-finance-campaign/>
24. <https://www.dartmouth.edu/~nyhan/judicial-financing-reform.pdf>
25. https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=3118942
26. <https://www.cecc.gov/judicial-independence-in-the-prc>



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

ШҮҮГЧДЭЭС АВАХ АСУУЛГЫН ХУУДАС

Монгол Улсын эрхэм шүүгч Танд энэ өдрийн мэнд хүргэе!

Судалгааны зорилго: Шүүгчийн нөлөөллийн мэдүүлэгт дүн шинжилгээ хийх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулах зорилгоор энэхүү судалгааг явуулж байна. Таны өгсөн мэдээллийн нууцлалыг чандлан хадгалж, зөвхөн судалгааны зориулалтаар ашиглах тул судалгаанд идэвх гаргахыг хүсье. Та өөрийн нэр болон албан тушаалыг бичих шаардлагагүй болно.

Нэг. Нийгэм хүн ам зүйн мэдээлэл

1. Аймаг/ Нийслэл /доогуур зурах/
2. Таны нас.....
3. Таны хүйс а.Эрэгтэй б.Эмэгтэй
4. Шүүхийн төрөл
 - а. Эрүү
 - б. Иргэн
 - в. Захиргаа
5. Таны ажилласан жилийн туршлага
 - а. 1 жил хүртэл
 - б. 1-3 жил хүртэл
 - в. 4-6 жил хүртэл
 - г. 7-10 жил хүртэл
 - д. 10-аас дээш жил



Хоёр. Судалгааны асуулга

1. Та нөлөөллийн мэдүүлэг хөтлөх талаар ямар ойлголттой байдаг вэ?
 - а. Маш сайн
 - б. Сайн
 - в. Дунд зэрэг
 - г. Муу
2. Та нөлөөллийн мэдүүлэг хөтөлж байсан уу?
 - а.Тийм б.Үгүй
3. Шүүн таслах ажиллагаа явуулахад Танд хэн нэгэн этгээдээс аль нэг хэлбэрээр нөлөөлөх гэж оролдож байсан уу?
 - а. Байнга
 - б. Хэд хэдэн удаа
 - в. Ганц, хоёр удаа
 - г. Санахгүй байна
 - д. Үгүй
4. Тийм бол Танд ямар хэлбэрээр нөлөөлөх гэж оролдож байсан бэ? /хэд хэдэн сонголтоор бөглөх боломжтой/
 - а. Хээл хахууль, шан харамж, бэлэг сэлт өгөхийг завдах
 - б. Шүүгч болон гэр бүлийн гишүүдэд албан тушаал санал болгох

- в. Дарамт шахалт үзүүлэх
- г. Дарамтлах, заналхийлэх
- д. Доромжлох, гүтгэх
- е. Шүүгчийн бие, орон байр, унааны аюулгүй байдалд халдах
- ё. Шийдвэрийг урьдчилан хэлэлцэхийг санал болгох
- ж. Шийдвэрийн талаар урьдчилан зааварчилгаа өгөх
- з. Нөхцөл байдлыг тайлбарлах
- и. Бусад хэрэг, маргааны шийдвэрийг жишиг болгохыг санал болгох
- й. Бусад.....хэлбэрийг бичнэ үү.

5. Хэрэг маргааны шийдвэрлэлттэй холбогдуулан Танд нөлөөлөх оролдлого үзүүлсэн этгээд аль нь вэ? /хэд хэдэн сонголтоор бөглөх боломжтой/
- а. Томилох эрх бүх албан тушаалтан
 - б. Улс төрийн албан тушаалтан
 - в. Прокурор
 - г. Өмгөөлөгч
 - д. Хэргийн оролцогч
 - е. Тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч
 - ё. Дээд шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч
 - ж. Шүүхийн ерөнхий зөвлөл
 - з. Бусад.....бичнэ үү.
6. Танд нөлөөлөх гэж оролдсон этгээдийн үйлдэлд мэдүүлэг хөтлөөгүй шалтгаан юу вэ? /хэд хэдэн сонголтоор бөглөх боломжтой/
- а. Ажлын ачаалал их /цаг, зав гараагүй/
 - б. Журамд заасан ажиллагааг хийхэд төвөгтэй /тайлбар гаргах, мэдүүлэг өгөх/
 - в. Нөлөөллийн мэдүүлэг хөтөлснөөр ирж болох дарамт шахалтаас эмээдэг
 - г. Нөлөөллийн мэдүүлгийн хэлбэрт бүх талын нөлөөлөл тусгагдаагүй
 - д. Танил тал татдаг
 - е. Мэдүүлэг хөтлөх талаарх ойлголт муу
 - ё. Байхгүй
 - ж. Бусад шалтгаан.....-ыг бичнэ үү.
7. Та Монгол улсад шүүгчийн хараат бус байдал хэр зэрэг хангагдсан гэж үздэг вэ?
- а. Сайн
 - б. Дунд
 - в. Муу
 - г. Хангагдаагүй
8. Та шүүгчийн хараат бус байдлыг хангахад ямар хүчин зүйл чухал нөлөөтэй гэж үздэг вэ? /хэд хэдэн сонголтоор бөглөх боломжтой/
- а. Эдийн засгийн баталгаа
 - б. Хууль зүйн баталгаа
 - в. Томилгооны хараат бус байдал
 - г. Шүүгчийн өөрийнх нь ёс зүй, мэдлэг мэргэшил, ур чадвар
 - д. Дээрх бүгд
 - е. Мэдэхгүй
9. Та шүүгчийн хараат бус байдлыг хангахад нөлөөллийн мэдүүлэг хөтлөх хэлбэр нь хэр үр дүнтэй гэж үзэж байна вэ?
- а. Маш сайн
 - б. Сайн
 - в. Дунд зэрэг
 - г. Муу
 - д. Үр дүн гараагүй

10. Та шүүгч хараат бус, нөлөөллөөс ангид байх нь шүүгчээс өөрөөс нь их хамааралтай гэдэгтэй санал нийлдэг үү?
- а. Санал нийлдэг
 - б. Зарим талаар санал нийлдэг
 - в. Санал нийлэхгүй
 - г. Огт санал нийлэхгүй
11. Шүүгчид өөрсдийн хянан шийдвэрлэж буй хэргийн талаар санал солилцох, урьдчилан хэлэлцэх, зааварчилгаа өгөх зэргээр хоорондоо хэр харилцдаг вэ?
- а. Байнга
 - б. Заримдаа /хэргийн ээдрээ төвөгтэй байдлаас шалтгаалж/
 - в. Ажил хэргийн хувьд хандах шаардлага гардаг
 - г. Хандах шаардлага гардаггүй
12. Танд тухайн хэрэг, маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар шүүгч, Ерөнхий шүүгчээс зааварчилгаа өгөх тохиолдол байдаг уу?
- а. Байдаг
 - б. Зарим тохиолдолд байдаг
 - в. Байдаггүй
 - г. Зааварчилгаа биш зөвлөгөө өгөх тохиолдол байдаг
 - д. Тийм зүйл байх ёсгүй
13. Та “Нөлөөллийн мэдүүлэг шийдвэрлэх журам”-ын хэрэгжилтийг сайжруулахад аль хүчин зүйл нөлөөтэй гэж үзэж байна вэ? /хэд хэдэн сонголтоор бөглөх боломжтой/
- а. Шүүгчдэд нөлөөллийн мэдүүлгийн талаарх сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах
 - б. Журмыг шинэчлэх, /процессын ажиллагааг тодорхой заах, нөлөөлөх хэлбэрийн талаар албан ёсны тайлбар гаргуулах/
 - в. Хөтөлсөн мэдүүлгийн нууцлалыг нууцын журмаар хангах
 - г. Нөлөөлсөн тухай мэдээллийг хуульд заасан хугацаанд олон нийтэд мэдээлэх
 - д. Журмын хэрэгжилтийг сайжруулах чиглэлд захиргааны хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх
 - е. Төрийн байгууллагуудын хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах хүрээнд тодорхой арга хэмжээ авах
 - ё. Дээрх бүгд
 - ж. Бусад.....-ыг бичнэ үү.

Асуулгад чин сэтгэлээсээ хандаж, хариулсан Танд талархал илэрхийлье.